



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 263

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8; 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм"-ийг 1 дүгээр, "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"-ийг 2 дугаар, тээврийн дагалдах бичгийн загварыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эдгээр дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Гомбосүрэн/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/, орон нутгийн удирдлага, Далайн захиргаа УТҮГ-т тус тус даалгасугай.

3. "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"- батлагдсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 275 дугаар тушаал, мөн Зам, тээврийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 138 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ж.БАТ-ЭРДЭНЭ

2017.12.12

1. Дүрэм батлуулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Усан замын тээвэр зогсонги байсан 1990-2009 онуудад тус улсын томоохон гол, мөрөн, нууруудад тун цөөхөн усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр зөвхөн Хөвсгөл нуурт иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 80 гаруй усан замын тээврийн хэрэгсэл байгаа ба цаашид нийт гол, мөрөн, нуурт улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна.


Усан замын тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэхийн хэрээр усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн эрчим, нягтрал нэмэгдэж, усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчид согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ усан замын тээврийн хэрэгсэл жолоодох, зорчигч, аялагч тээвэрлэж явахдаа тэдний анхаарал, сонирхлыг татах зорилгоор усны мандалд эргэлт хийх, элдэв үзүүлбэр үзүүлэх, аврах хантаазгүйгээр зорчигч тээвэрлэх, хөвөлтөд оролцохдоо бусад усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд аюул учруулахаар гүйцэж түрүүлэх, буруу талаар зөрж өнгөрөх, хөдөлгөөний чиглэлийг нь сүлжих, урдуур хойгуур нь тойрох зэргээр бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулах зэрэг үйлдлийг гаргаж байгаа нь усан замын тээврийн хэрэгслүүд хоорондоо мөргөлдөх, хүний амь нас осолдох эрсдлийг ихэсгэж байгаа тул тэднийг үүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, чадвартай болгох зорилгоор усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын (усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох) дүрмийг мөрдүүлнэ.

Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8-д "усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм боловсруулах, батлах" гэж заасны дагуу уг дүрмийг боловсруулж усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлуулна.

2. Дүрмийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Дүрмийн төсөл нь нийтлэг үндэслэл, усан замын тээврийн хэрэгслийн ангилал, өмчлөгч, эзэмшигч, ахмад, жолоочийн үүрэг, хариуцлага, усан замд хөвөлтийн болон байгаль цаг уурын янз бүрийн нөхцөлд баримтлах усан замын тээврийн хэрэгсэл жолоодох дүрэм, усан замын тээврийн хэрэгслийг шөнө болон үзэгдэх орчин хязгаарлагдсан үед жолоодох, дуут дохио өгөх, усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн өдрийн болон шөнийн гэрэл дохио, тэмдгийг хэрэглэх, зангуу ашиглах, аврах хантаазны төрөл загвар, хэрхэн ашиглах, луужин, газрын зураг бусад хөвөлтийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжтэй байх, хэрэглэж чаддаг байх, гал унтраах багаж хэрэгсэл, аюул ослын үед өгөх дохио тэмдэгтэй байх, усны мотоциклийг аюул осолгүй жолоодох, усны түвшинг анхаарах зэрэг усан замд хамаарах бүх л асуудлыг багтаасан.

Дүрмийн төсөлд усан замын тээврийн хэрэгслийн жолооч, ахмад, өмчлөгч, эзэмшигчид нь усан замд өөр бусад усан замын тээврийн хэрэгсэлтэй халз тулгарах, гүйцэж түрүүлэх, зөрж өнгөрөх зэрэг усан замын хөвөлтийн бүх тохиолдлуудад өөрийн тээврийн хэрэгслээ осол аюулгүй жолоодох, удирдах, үүний тулд ямар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, усан замын өдрийн болон шөнийн гэрэл дохио тэмдгүүдийг ялган таньж удирдлага жолоодлогодоо хэрэглэдэг байх,



тэдгээр дохио, тэмдгүүдэд тавигддаг шаардлагын дагуу өөрийн усан замын тээврийн хэрэгслийг ангилал, зориулалтад нь нийцүүлэн тоноглосон байх, үзэгдэх орчин хязгаарлагдсан, шөнийн цагт хэрхэн хөвөх, дуут дохиог хэрхэн ашиглах, аврах хантаазыг ангилал зориулалтаар нь хэрхэн ашиглах зэрэг усан замын хөвөлтийн аюулгүй байдалтай холбоотой бүх арга хэмжээ, үйл ажиллагааг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх мэдлэг чадвартай байх тэдний үүрэг хариуцлагыг тусгаж зохицуулсан болно.

Энэхүү дүрэм нь усан замын тээврийн хэрэгсэл аялах боломжтой Монгол Улсын гол, мөрөн, нуурын усан мандалд хөвж буй усан замын тээврийн хэрэгслүүдэд үйлчилнэ. Дүрмийн заалтыг зөрчсөн хүн, хуулийн этгээд нь Усан замын тээврийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан хэм хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

3. Дүрмийн төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Дүрмийн төсөл батлагдсаны дараа усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй. Усан замын тээврийн хэрэгслээр үйлчлүүлэгч иргэд, аялагчдын аюулгүй байдал хангагдаж, эрх ашиг нь хамгаалагдана.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, дүрмийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, эдийн засгийн тооцоо.

Дүрмийн төсөлд тусгагдсан харилцааг өмнө нь зохицуулсан ямар нэгэн дүрэм, журам, заавар байхгүй бөгөөд шинэчлэгдэн батлагдсан Усан замын тээврийн тухай хуульд заасан тавигдаж буй шаардлагын дагуу дүрмийг шинээр боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, санхүү, эдийн засгийн зардал гарахгүй болно.

Дүрмийн төсөл батлагдсанаар усан замын тээврийн хэрэгслийн жолооч, ахмад нар хөвөлтийн үед ямар ямар үйлдэл, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагын талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй болж, улмаар усан замын тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, түүний улмаас хүний амь нас, эд хөрөнгө хохирох эрсдэл буурч, хөвөлтийн аюулгүй байдал хангагдана.

САЙД

БАТ-ЭРДЭНЭ

Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын
(усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох)
дүрмийн танилцуулга

2017.12.12

Манай Улсын усан замын тээвэр 1950-иад оноос 1980-аад оны сүүл хүртэл нилээд эрчимтэй хөгжиж, 1 чирэгч, 3 чиргүүл онгоцоор ОХУ-аас импортолж буй өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал бусад ачааг Ханх, Хатгал боомтын хооронд Хөвсгөл нуураар тээвэрлэж баруун аймгуудыг хангаж байсан ба Сэлэнгэ мөрнөөр гол төлөв мод бэлтгэл, үр тарианы тээвэрлэлт хийгдэж байв.


Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос хойш ОХУ-аас импортлох барааны ачаа эргэлт үгүй болсон, өмч хувьчлагдсан, хөдлөх бүрэлдэхүүн хуучирсан, мөн байгаль орчны асуудлаас болж усан замын тээвэр 2000 оны дунд үе хүртэл зогсонги байлаа.

Монгол Улсын Усан замын тээвэр зогсонги байсан 1990-2009 онуудад тус улсын томоохон гол, мөрөн, нууруудад тун цөөхөн усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр зөвхөн Хөвсгөл нуурт иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 80 гаруй усан замын тээврийн хэрэгсэл байгаа ба цаашид нийт гол, мөрөн, нуурт улам бүр нэмэгдэх хандлагатай болж байна.

Усан замын тээврийн хэрэгслийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэхийн хэрээр усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн эрчим, нягтрал нэмэгдэж, усан замын тээврийн хэрэгсэл жолоодогчид согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ усан замын тээврийн хэрэгсэл жолоодох, зорчигч, аялагч тээвэрлэж явахдаа тэдний анхаарал, сонирхлыг татах зорилгоор усны мандалд эргэлт хийх, элдэв үзүүлбэр үзүүлэх, аврах хантаазгүйгээр зорчигч тээвэрлэх, хөвөлтөд оролцохдоо бусад усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд аюул учруулахаар гүйцэж түрүүлэх, буруу талаар зөрж өнгөрөх, хөдөлгөөний чиглэлийг нь сүлжих, урдуур хойгуур нь тойрох зэргээр бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулах зэрэг үйлдлийг гаргаж байгаа нь усан замын тээврийн хэрэгслүүд хоорондоо мөргөлдөх, хүний амь нас осолдох эрсдлийг ихэсгэж байгаа тул тэднийг үүнээс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, чадвартай болгох зорилгоор усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын (усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох) дүрмийг боловсруулсан болно.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганаар Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8-д "усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм боловсруулах, батлах" гэж заасан нь уг дүрмийг боловсруулах үндэслэл болсон.

Дүрмийн төсөл нь нийтлэг үндэслэл, усан замын тээврийн хэрэгслийн ангилал, өмчлөгч, эзэмшигч, ахмад, жолоочийн үүрэг, хариуцлага, усан замд хөвөлтийн болон байгаль цаг уурын янз бүрийн нөхцөлд баримтлах усан замын тээврийн хэрэгсэл жолоодох дүрэм, усан замын тээврийн хэрэгслийг шөнө болон үзэгдэх орчин хязгаарлагдсан үед жолоодох, дуут дохио өгөх, усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн өдрийн болон шөнийн гэрэл дохио, тэмдгийг хэрэглэх, зангуу ашиглах, аврах хантаазны төрөл загвар, хэрхэн ашиглах, луужин, газрын зураг



бусад хөвөлтийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай тоног төхөөрөмжтэй байх, хэрэглэж чаддаг байх, гал унтраах багаж хэрэгсэл, аюул ослын үед өгөх дохио тэмдэгтэй байх, усны мотоциклийг аюул осолгүй жолоодох, усны түвшинг анхаарах зэрэг усан замд хамаарах бүх харилцааг зохицуулсан.


Дүрмийн төсөлд усан замын тээврийн хэрэгслийн жолооч, ахмад, өмчлөгч, эзэмшигчид нь усан замд өөр бусад усан замын тээврийн хэрэгсэлтэй халз тулгарах, гүйцэж түрүүлэх, зөрж өнгөрөх зэрэг усан замын хөвөлтийн бүх тохиолдлуудад өөрийн тээврийн хэрэгслээ осол аюулгүй жолоодох, удирдах, үүний тулд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, усан замын өдрийн болон шөнийн гэрэл дохио тэмдгүүдийг ялган таньж удирдлага жолоодлогодоо хэрэглэдэг байх, тэдгээр дохио, тэмдгүүдэд тавигддаг шаардлагын дагуу өөрийн усан замын тээврийн хэрэгслийг ангилал, зориулалтад нь нийцүүлэн тоноглогсон байх, үзэгдэх орчин хязгаарлагдсан, шөнийн цагт хэрхэн хөвөх, дуут дохиог хэрхэн ашиглах, аврах хантаазыг ангилал зориулалтаар нь хэрхэн ашиглах зэрэг усан замын хөвөлтийн аюулгүй байдалтай холбоотой бүх арга хэмжээ, үйл ажиллагааг цаг тухайд нь авч хэрэгжүүлэх мэдлэг чадвартай байх, тэдний үүрэг хариуцлагыг тусгаж зохицуулсан болно.

Дүрмийн төсөлд тусгагдсан харилцааг өмнө нь зохицуулсан ямар нэгэн дүрэм, журам, заавар байхгүй бөгөөд шинэчлэн батлагдсан Усан замын тээврийн тухай хуулиар тавигдаж буй шаардлагын дагуу дүрмийг шинээр боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, санхүү, эдийн засгийн зардал гарахгүй болно.

Энэхүү дүрэм нь усан замын тээврийн хэрэгсэл хөвөх боломжтой Монгол Улсын гол, мөрөн, нуурын усан мандалд хөвж буй усан замын тээврийн хэрэгслүүдэд үйлчилнэ. Дүрмийн заалтыг зөрчсөн хүн, хуулийн этгээд нь Усан замын тээврийн тухай болон Зөрчлийн тухай хуульд заасан хэм хэмжээгээр хариуцлага хүлээх болно.

Дүрмийн төсөл батлагдсанаар усан замын тээврийн хэрэгслийн жолооч, ахмад хөвөлтийн үед ямар үйлдэл, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагын талаар бүрэн мэдлэгтэй болж, улмаар усан замын тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, түүний улмаас хүний амь нас, эд хөрөнгө хохирох эрсдэл буурч, хөвөлтийн аюулгүй байдал хангагдана.

— оОо —



**Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын
(усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох)
дүрэм**



1. Нийтлэг үндэслэл

1.1. Усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох дүрэм (цаашид "Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм" гэх) - ийн зорилго нь усан замын тээврийн хэрэгсэл хөвөх боломжтой Монгол Улсын гол, мөрөн, нуурын усан мандалд хөвж, ажил, үйлчилгээ эрхэлж буй усан замын тээврийн хэрэгсэл (цаашид "усан замын тээврийн хэрэгсэл" гэх) -ийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангасан нийтлэг журам тогтоож мөрдүүлэх, усан замд тохиолдож болзошгүй аюул ослыг урьдчилан харж, түүнээс сэргийлэхэд оршино.

1.2. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалтай холбоотой бусад хэм хэмжээний актууд нь Усан замын тээврийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, энэ дүрмийн заалт шаардлагад үндэслэгдсэн, түүнтэй зөрчилдөхгүй байвал зохино.

2. Усан замын тээврийн хэрэгслийн ангилал

2.1. Усан замын тээврийн хэрэгслийг Усан замын тээврийн¹ тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасны дагуу ангилна.

2.2. Дунд, том оврын усан замын тээврийн хэрэгслийг 21-ээс дээш насны далай, усан замын чиглэлээр мэргэжлийн сургууль төгссөн дипломтой, ижил ангиллын тээврийн хэрэгсэл дээр 1-2 жил ажилласан, хөвөлтийн зохих дадлага туршлагатай хүн; жижиг, бага оврын тээврийн хэрэгслийг 18-аас дээш насны гадаад улс оронд болон дотоодод далай, усан замын чиглэлээр мэргэжлийн сургалтад хамрагдаж усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх авсан, хөвөлтийн зохих туршлагатай хүн жолоодно.

3. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, ахмад, жолооч (цаашид "жолооч" гэх)-ийн үүрэг

3.1. Хөвөлтийн дадлага туршлагатай байх - гэдэг нь усан замын тээврийн хэрэгсэл мөргөлдөх, шүргэлцэхээс зайлсхийхэд шаардлагатай бүх арга хэмжээ, үйлдлийг байгаль, цаг уурын нөхцөл, бусад усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн нягтрал, удирдлага, жолоодлогын хязгаарлалт зэргийг тооцож авч хэрэгжүүлэх жолоочийн чадвар болно. Энэхүү арга хэмжээ, үйлдлийг бусад усан замын тээврийн хэрэгслээс хол, аюулгүй зайд, мөргөлдөхөөс зайлсхийх хангалттай хугацаа байх үед авч хэрэгжүүлнэ.

¹ Усан замын тээврийн тухай хууль, "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн

3.2. Ажиглалт сайтар хийх - аялал үргэлжлэх бүх цаг хугацааны туршид хүрээлэн буй орчноо ажиглаж, бусад усан замын тээврийн хэрэгслийн радио холбоо, дуут дохиог сонсож, гэрэлт болон бусад дохиог ажиглан усан замын тээврийн хэрэгслийн удирдлага, жолоодлогод учрах эрсдлүүдээс урьдчилан сэргийлэх зорилгоор усны мандалд явагдаж буй бусад үйл ажиллагааг хянана.

Ажиглалт хийхдээ ойртож ирэх, зөрж өнгөрөх, эгц өөдөөс халз тулгарах усан замын тээврийн хэрэгсэл нь ямар хөдөлгүүртэй байна вэ? эсхүл хөдөлгүүргүй, дарвуулт усан онгоц уу? гэдгийг болон тухайн усан замын тээврийн хэрэгсэл чиглэл огтлолцох, зам хөндлөн гарах, гүйцэж түрүүлэх зэрэг үйлдлийн алийг нь хийх гэж буйг тодорхойлно.

3.3. Аюулгүй хурдыг сонгож, хурдаа хэвээр хадгалах- аюулгүй хурд нь тухайн нөхцөл байдалдаа тохируулж сонгох хурд бөгөөд салхи, давалгаа, усны нөхцөл байдал, усан замын тээврийн хэрэгслийн удирдлага, жолоодлогын эрсдлүүд, үзэгдэх орчин, эргэн тойронд хөвж буй усан замын бусад тээврийн хэрэгслийн хөвөлтийн нягтрал, усан замын тээврийн хэрэгсэл, завь, усны мотоциклийн маневрлах чадвар зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өөр өөр байна. Шөнийн аялалд болон үзэгдэх орчин хязгаарлагдсан үед бага хурдаар, өндөр сонор сэрэмж анхааралтайгаар усан замын тээврийн хэрэгслээ жолоодно.

3.4. Бусад усан замын тээврийн хэрэгслийн урдуур хөндлөн гарахаас зайлсхийх. Чиглэл болон хурдаа өөрчлөхдөө бусад усан замын тээврийн хэрэгсэлд ямар нэг бэрхшээл, хүндрэлгүй шууд харагдахаар нэг үйлдлээр, жижиг жижиг цуврал өөрчлөлт хийхээс зайлсхийж хангалттай өөрчилнө.

3.5. Хүч дамжуулах удирдлага /механик хөдөлгүүртэй/ -тай усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь дараах усан замын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Үүнд:

3.5.1. багийн бүрэлдэхүүнгүй аливаа усан замын тээврийн хэрэгсэл, тухайлбал, зангуугаа хаяж зогссон, эвдэрсэн;

3.5.2. гүйцэж түрүүлэхээс бусад үед дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл;

3.5.3. усан замын тээврийн хэрэгсэл чирч буй, шугам кабель тавьж буй, усан замын тээврийн хэрэгслийн удирдлага, жолоодлогын тэмдгийн засвар үйлчилгээ хийж буй, өөрийн суултын улмаас хөвөлт нь удааширсан, нарийн хоолой, сувгаар хөвж буй том оврын усан замын тээврийн хэрэгсэл гэх мэт маневрлах чадвар нь хязгаарлагдсан аливаа усан замын тээврийн хэрэгсэл.

3.6. Дарвуулт усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь дараах усан замын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Үүнд:

3.6.1 багийн бүрэлдэхүүнгүй аливаа усан замын тээврийн хэрэгсэл (зангуугаа хаяж зогссон, эвдэрсэн);

3.6.2 маневрлах чадвар нь хязгаарлагдсан аливаа усан замын тээврийн хэрэгсэл.

3.7. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч мөргөлдөх, шүргэлцэх эрсдэл үүссэн аливаа нөхцлүүд, түүний дотор осолд орсон усан замын тээврийн хэрэгсэлтэй холбоотой хязгаарлалтууд зэрэг усан замын тээврийн хэрэгслийн



удирдлага, жолоодлогод учирч болзошгүй бүх аюулаас сэргийлж нэн хянамгай байна.

3.8. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь тусламж үзүүлэх үйл ажиллагаа нь өөрийн жолоодож буй усан замын тээврийн хэрэгсэл, эсвэл зорчигчдыг аюул, ослын эрсдэлд оруулахааргүй байвал, аюул осолд орсон усан замын тээврийн хэрэгсэлд тусламж үзүүлнэ.

3.9. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь өөрийн тээврийн хэрэгслийг ангилал, зориулалтынх нь дагуу нутгийн захиргааны эрх бүхий байгууллагаас тухайн тээврийн хэрэгсэл хөвөхөөр тогтоосон бүсэд ашиглах ба амралт, наран шарлагын бүсэд үл зорчино. Жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүд нуурын эргээс 150 м хүртэл зайд хөвнө.

3.10. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь түүний жолоодож буй тээврийн хэрэгслээс маневрлах чадвараар муу, эсхүл маневрлах чадвар нь хязгаарлагдсан усан замын тээврийн хэрэгсэлд эерж өнгөрөх, гүйцэж түрүүлэх давуу эрх олгож зам тавьж өгнө.

3.11. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь түүний жолоодож буй тээврийн хэрэгсэлд шууд заналхийлсэн аюул ослоос нэн даруй зайлсхийх зайлшгүй шаардлагатай тохиолдолд энэхүү дүрмийг баримтлахгүй байж болно.

4. Усан замын тээврийн хэрэгсэл, усан замын бусад тээврийн хэрэгсэлтэй халз тулгаран зөрөх:

4.1. Халз тулгаран зөрөх


4.1.1. хүч дамжуулах удирдлагатай хоёр усан замын тээврийн хэрэгсэл халз тулгарсан бол хоёр усан замын тээврийн хэрэгслийн жолооч хоёулаа баруун гар тийш жолоогоо залж зөрж өнгөрөх ба аль аль нь хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.1.2. хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгсэл, дарвуулт усан замын тээврийн хэрэгсэлтэй халз тулгаран зөрөх тохиолдолд хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгслийн жолооч дарвуулт усан замын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.2. Чиглэл огтлолцох, зам хөндлөн гарах

4.2.1. хүч дамжуулах удирдлагатай хоёр усан замын тээврийн хэрэгслийн чиглэл огтлолцож зам хөндлөн гарахаар бол бага оврын усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь том оврын усан замын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Том оврын усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.2.2. хүч дамжуулах удирдлагатай нэг буюу түүнээс олон усан замын тээврийн хэрэгслийн чиглэл, дарвуулт усан замын тээврийн хэрэгслийн чиглэлтэй огтлолцож зам хөндлөн гарах тохиолдолд хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгслийн жолооч дарвуулт усан замын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.



4.3. Гүйцэж түрүүлэх

4.3.1. хүч дамжуулах удирдлагатай хоёр усан замын тээврийн хэрэгсэл аль нэгийгээ баруун, эсвэл зүүн талаар нь гүйцэж түрүүлж болно. Гүйцэгдэж буй усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.3.2. дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл, хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгслийг баруун, эсвэл зүүн талаар нь гүйцэж түрүүлж болно. Гүйцэгдэж буй усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.3.3. хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгсэл, дарвуулт усан замын тээврийн хэрэгслийг баруун, эсвэл зүүн талаар нь гүйцэж түрүүлж болно. Гүйцэгдэж буй усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.4. Дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл, дарвуулт усан замын тээврийн хэрэгсэлтэй зөрөх, чиглэл огтлолцох, хөндлөн гарах

4.4.1. зүүн хажуу тал руу нь салхи үлээж байгаа дарвуулт усан замын тээврийн хэрэгслийн жолооч чиглэлийг нь огтлон гарахаар салхи сөрөн хөвж буй дарвуулт усан замын тээврийн хэрэгслийн баруун, эсхүл зүүн хажуу тал руу нь салхи үлээж байгаа эсэхийг тодорхойлж чадахгүй тохиолдолд салхины эсрэг хөвж буй дарвуулт усан замын тээврийн хэрэгсэлдээ зам тавьж өгнө.

4.4.2. дарвуулт хоёр усан замын тээврийн хэрэгслийн ижил хажуу тал руу салхи үлээж байгаа үед бие биедээ шахаж зөрөх тохиолдолд салхины доод талаас ирж буй дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.4.3. дарвуулт хоёр усан замын тээврийн хэрэгслийн өөр өөр хажуу тал руу салхи үлээж байгаа үед бие биедээ шахаж зөрөхөөр бол баруун хажуу тал руу нь салхи үлээж байгаа дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл нь давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

4.5. Үзэгдэх орчин хязгаарлагдсан үед усан замын тээврийн хэрэгсэл жолоодох


4.5.1. үзэгдэх орчин хязгаарлагдсан тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийг өндөр сонор сэрэмж анхааралтай жолоодно.

4.5.2. үзэгдэх орчин 0.3 км хүртэл хязгаарлагдсан тохиолдолд жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийг хөвөлтөд гаргахыг хориглоно.

4.5.3. бие биеэ харахгүй байгаа усан замын тээврийн хэрэгслийн жолооч дараахь байдлаар хоорондоо харилцана. Үүнд:

4.5.3.1. үзэгдэх орчин хязгаарлагдсан тухайн нөхцөл байдлаар өгөгдсөн аюулгүй хурдаар усан замын тээврийн хэрэгсэлээ жолоодно. Хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгсэл нь хөдөлгүүрээ нэн даруй маневрлахад бэлэн байлгана;

4.5.3.2. өмнөө маш ойрхон хөвж буй өөр усан замын тээврийн хэрэгслийн манан будангийн дохиог сонссон, эсвэл өөр усан замын тээврийн хэрэгсэл хөвж байгааг илрүүлэгч төхөөрөмж /радар/ -өөр илрүүлсэн жолооч нь мөргөлдөх эрсдэлгүй бол өөрийн усан замын тээврийн хэрэгслийн



чиглэлийг хэвээр хадгалах боломж олгох хамгийн доод хурд хүртэл хурдаа бууруулна. Шаардлагатай бол хурдаа хасч, зөвхөн үндсэн жолоог ажиллуулах бололцоотой хэмжээнд хурдаа бууруулна.

5. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангах дохионы гэрлүүд:

5.1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангах дохионы гэрлүүд нь усан замын тээврийн хэрэгслүүд шөнийн цагаар бие биетэйгээ зөрж өнгөрөхдөө хэн нь зам тавьж өгөхийг тодорхойлно. Эдгээр дохионы гэрлийг нар жаргах цагаас нар ургах хүртэл болон үзэгдэх орчин хязгаарлагдсан, манан будантай үед асаах ба үүнтэй андуурч харах өөр бусад гэрэл асаахыг хориглоно.

5.2. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангах дохионы үндсэн 4 гэрэл байна. Үүнд:

5.2.1. хажуугийн гэрлүүд: эдгээр нь улаан ба ногоон өнгөтэй гэрэл байх ба усан замын тээврийн хэрэгслийн хоёр хажуугаас тодорхой өнцгөөр тусах учир зөвхөн эгц урдаас, эсвэл хажуу талаас ойртож ирэх үед л өөр бусад усан замын тээврийн хэрэгслийн жолоочид харагдана. Улаан гэрэл нь усан замын тээврийн хэрэгслийн зүүн гар талыг, ногоон гэрэл нь баруун гар талыг заана;

5.2.2. арын гэрэл: цагаан өнгөтэй энэхүү гэрэл нь усан замын тээврийн хэрэгслийн ард талд тодорхой өнцгөөр тусдаг тул зөвхөн чанх ар талаасаа бусад усан замын тээврийн хэрэгслийн жолоочид харагдана;


5.2.3. гол шурагын гэрэл: цагаан өнгийн гэрэл бөгөөд усан замын тээврийн хэрэгслийн хошуу /хамар/ болон хоёр хажуу талыг тодорхой өнцгөөр гэрэлтүүлнэ;

Хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн бүх хэрэгслийг ийм гэрлээр тоноглоно. (Жижиг оврын хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгслийн гол шурагын гэрэл ба арын гэрлийг нэгтгэж тойрон (360°) гэрэлтүүлэх цагаан гэрлээр сольж болох ба бага, дунд оврын хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгслийн гол шурагын гэрэл нь тусдаа байна).

Хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн бүх хэрэгсэл гол шурагын гэрлээ шөнийн цагаар асаана. Гол шурагын гэрэлгүй бол дарвуулт усан онгоц гэж үзнэ. Дарвуулт усан онгоц нь зөвхөн хажуугийн болон арын гэрлээ асаана.

5.2.4. тойрон (360°) гэрэлтүүлэх цагаан гэрэл: жижиг оврын хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгслүүдэд энэхүү гэрэл нь гол шурагын гэрэл болон арын гэрлийг нэгтгэсэн хэлбэрээр байж болох ба бусад усан замын тээврийн хэрэгсэлд аль ч чиглэл (360°) -ээс харагдах нэг цагаан гэрэл байна. Хажуугийн гэрлийг унтраасан үед энэхүү гэрлийг зангууны гэрэл гэж үзнэ.

5.3. Усан замын тээврийн хэрэгсэлд зайлшгүй шаардлагатай хөвөлтийн аюулгүй байдлыг хангах дохионы гэрлүүд нь усан замын тээврийн хэрэгслийн төрөл, загвар, уртаас хамаарч ялгаатай байна. Үүнд:



4/2

5.3.1. жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслүүд шөнийн цагт асаах гэрлүүд:

- 3,2 км-ийн алсаас харагдах хүчин чадалтай гол шурагын цагаан гэрэл;
- 1,6 км-ийн алсаас харагдах хоёр хажуугийн улаан, ногоон гэрэл;
- жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийг чирч буй бол 3,2 км-ийн алсаас харагдах шар гэрэл;
- жижиг, бага оврын дарвуулт болон хөдөлгүүргүй усан замын тээврийн хэрэгслүүд гол шураг дээрээ 3,2 км-ийн алсаас харагдах цагаан, ногоон, улаан хосолсон гэрэл;
- эсхүл тойрон эргэлдэх улбар шар гэрэл;
- эсхүл 3,2 км-ийн алсаас харагдах тусгай анивчсан гэрлийг тус тус асаана.

5.3.2. дунд оврын усан замын тээврийн хэрэгслүүд шөнийн цагт асаах гэрлүүд:


- 4,8 км-8,0 км-ийн алсаас харагдах гол шурагын цагаан гэрэл;
- 3,2 км-ийн алсаас харагдах хоёр хажуугийн улаан, ногоон гэрэл;
- 3,2 км-ийн алсаас харагдах арын гэрэл;
- дунд оврын усан замын тээврийн хэрэгслийг чирч буй бол 3,2 км-ийн алсаас харагдах шар гэрэл;
- дунд оврын дарвуулт болон хөдөлгүүргүй усан замын тээврийн хэрэгслүүд гол шураг дээрээ 3,2 км-ийн алсаас харагдах цагаан;
- хошуун дээрээ ногоон, улаан хосолсон гэрэл;
- эсхүл тойрон эргэлдэх улбар шар гэрэл;
- эсхүл 3,2 км-ийн алсаас харагдах тусгай анивчсан гэрлийг тус тус асаана.

5.3.3. том оврын усан замын тээврийн хэрэгслүүд шөнийн цагт асаах гэрлүүд:

- 9,6 км-ийн алсаас харагдах гол шурагын цагаан гэрэл;
- 4,8 км-ийн алсаас харагдах хоёр хажуугийн улаан, ногоон гэрэл, арын гэрэл;
- том оврын усан замын тээврийн хэрэгслийг чирч буй бол 4,8 км-ийн алсаас харагдах шар гэрэл;
- том оврын дарвуулт болон хөдөлгүүргүй усан замын тээврийн хэрэгслүүд гол шураг дээрээ 4,8 км-ийн алсаас харагдах цагаан, хошуун дээрээ ногоон, улаан хосолсон гэрэл;
- эсхүл тойрон эргэлдэх улбар шар гэрэл;
- эсхүл 3,2 км-ийн алсаас харагдах тусгай анивчсан гэрлийг тус тус асаана.

5.3.4. усны мандалд ил харагдахгүй биет болон хагас живсэн усан замын тээврийн хэрэгсэл, объектыг чирч буй усан замын тээврийн хэрэгсэл 4,8 км-ийн алсаас харагдах тойрон эргэлдэж буй цагаан гэрлийг асаана.

5.3.5. замд яваа хүч дамжуулах удирдлагатай том оврын усан замын тээврийн хэрэгсэл эхний шураг дээрээ цагаан гэрэл, түүнээс дээш тодорхой өндөрт



гол шураг дээрээ хоёр дахь цагаан гэрэл (дунд оврын усан замын тээврийн хэрэгсэлд заавал шаардахгүй) асаах ба хажуугийн улаан ба ногоон гэрэл, арын гэрлээ мөн асааж хөвнө.

5.3.6. хийн дэр бүхий усан замын тээврийн хэрэгсэл нь ус үл түрэх горимд байхдаа энэ зүйлд заасан дохионы гэрлүүдээс гадна алсаас сайн харагдах анивчсан улбар шар гэрэл асаана.

5.3.7. хүч дамжуулах удирдлагатай жижиг оврын усан замын тээврийн хэрэгслүүд тойрон гэрэлтүүлэх цагаан гэрэл болон хажуугийн улаан, ногоон гэрлийг асааж хөвнө.

6. Усан замын тээврийн хэрэгслийг шөнө удирдах, жолоодох

6.1. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч шөнийн цагт үргэлж бага хурдаар хөвөх ба бусад усан замын тээврийн хэрэгслийн асаасан дохионы гэрлийг нэн анхааралтай ажиглаж, асаасан гэрлүүдээр нь тэдгээр усан замын тээврийн хэрэгсэл хүч дамжуулах удирдлагатай, эсвэл дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл уу гэдгийг болон тэдний аялалын чиглэлийг тодорхойлон усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрмээ баримтлан жолоодлогоо үргэлжлүүлнэ.

6.2. Бусад усан замын тээврийн хэрэгслийн дохионы гэрлүүд нь зохих ёсоор ажиллаж байгаа гэдэгт усан замын тээврийн хэрэгслийн жолооч хэзээ ч бүрэн итгэж болохгүй. Зам тавьж өгөх шаардлага гарч, цаг хугацааны нөөц болон орон зайн боломж байгаа бол, таны усан замын тээврийн хэрэгслийн гэрлүүд – давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгалахыг зааж байсан ч зам тавьж өгнө.

7. Хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгсэл, усан замын бусад тээврийн хэрэгслүүдтэй шөнийн цагаар зөрөх

7.1. Ногоон ба цагаан гэрэл харж байгаа жолооч, давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална. Бусад усан замын тээврийн хэрэгслийн удирдлага, жолооч таныг харахгүй буюу усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг мэдэхгүй байх тохиолдол гарч болзошгүй учраас байнгын бэлэн байдалд байна.

7.2. Зөвхөн цагаан гэрэл харж байгаа жолооч, өөр усан замын тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэх гэж байгаа, эсвэл замд явж байгаа давуу эрхтэй усан замын тээврийн хэрэгсэл, эсвэл зангуугаа буулгаж зогссон усан замын тээврийн хэрэгсэл байна гэж ойлгох бөгөөд түүнийг аль ч талаар нь тойрон гарч болно.

7.3. Улаан ба цагаан гэрэл харж байгаа жолооч, тухайн усан замын тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Хурдаа хасч тухайн усан замын тээврийн хэрэгслийг өнгөрөхийг зөвшөөрөх эсвэл баруун гар тийшээ эргэж түүний ар талаар зөрж өнгөрнө.

7.4. Улаан, ногоон болон цагаан гэрэл харж байгаа жолооч, хүч дамжуулах удирдлагатай өөр нэгэн усан замын тээврийн хэрэгслийн халз урдаас ойртож байна

45

гэж ойлгох ба хоёр усан замын тээврийн хэрэгсэл хоёулаа баруун гар тийш залуураа залж бие биедээ зам тавьж өгнө.

8. Дарвуулт усан замын тээврийн хэрэгслүүд шөнийн цагаар зөрөх

8.1. Улаан ба ногоон гэрэл харж байгаа, гэхдээ цагаан гэрэл харахгүй байгаа жолооч дарвуулт усан замын тээврийн хэрэгслийн халз урдаас нь ойртож байгаа гэж ойлгох ба зам тавьж өгнө.

8.2. Зөвхөн ногоон гэрэл, эсвэл зөвхөн улаан гэрэл харж байгаа жолооч, дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл рүү ойртож байна гэж ойлгох ба зам тавьж өгнө. Дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл нь гүйцэж түрүүлэхээс бусад тохиолдолд үргэлж давуу эрхтэй буюу хурд, чиглэлээ хэвээр хадгална.

9. Чирэгч (чиргүүл)-ийн гэрлүүдийг ажиглах

9.1. Шөнө орой чиргүүл /барж/-ийг түлхэх буюу чирч байгаа усан замын тээврийн хэрэгсэл арын гэрлийнхээ оронд нэг шар гэрлийг асаана. Хэрэв нэг буюу хэд хэдэн чиргүүл чирч, түлхэж буй тохиолдолд олон шар гэрэл асаана.

Чирч буй усан замын тээврийн хэрэгслийн асаасан гэрэл, түүний чиргүүлүүдийн урд болон ар хамар дээр асаасан гэрлийн хооронд хэдэн арван метрийн гэрэлтүүлээгүй орон зай байж болно. Тиймээс гэрэл хоорондуур гарахыг хориглоно.

10. Шөнийн цагаар усан замын тээврийн хэрэгсэл жолоодоход урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

10.1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дохионы гэрлүүд найдвартай ажиллаж буй эсэхийг шалгана. Нөөц гэрлийн шилийг авч явна.

10.2. Зангуутай зогсож байх үедээ тойрон (360°) гэрэлтүүлэх цагаан гэрлийг асаана.

10.3. Хурдаа хасч анхааралтай хөвнө.

10.4. Өмнө байгаа ямар нэгэн саад, зүйлээс онцгой сэрэмжтэй хөвнө. Шөнө ганцаараа аялахаас зайлсхийх ба шөнийн дуран, бусад тоног төхөөрөмжөөр усан замын тээврийн хэрэгслээ хангаж удирдана.

10.5. Үзэгдэх орчин бүр муудвал зогсох бөгөөд дуут дохиогоо дуугаргаж тухайн бүсэд хөвж буй бусад усан замын тээврийн хэрэгсэлд дохио өгнө.

11. Дуут дохио өгөх

11.1. Усан замын тээврийн хэрэгслийн дуут дохиог бусад усан замын тээврийн хэрэгсэлд ойртож ирснээ, зөрж өнгөрөх, эсвэл тэдэнд аюулын тухай сануулахад хэрэглэнэ. Дуут дохио нь үзэгдэх орчин хязгаарлагдсан бүх хугацааны туршид, тухайлбал өтгөн манан будантай үед бусад усан замын тээврийн хэрэгслийн байрлалыг тодорхойлох боломж олгодог.



11.2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч, нэн ялангуяа усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн эрчим, нягтралд үйл ажиллагаа явуулж буй усан замын тээврийн хэрэгслийн жолооч, өөрсдийн тээврийн хэрэгслийн дуут дохиог зохих ёсоор ажиллаж буйг заавал шалгана.

11.3. Дуут дохио нь богино болон урт дуунаас бүрдэх ба хамгийн багадаа 800 м орчим газар сонсогдохоор байна. Үүнд;

11.3.1. богино дуут дохио - 1 секунд үргэлжилнэ;

11.3.2. урт дуут дохио – 4-6 секунд үргэлжилнэ.

11.4. Зөрж өнгөрөх болон чиглэлээ өөрчлөх дуут дохио:

11.4.1. нэг удаагийн богино дуут дохио нь “Та миний зүүн хажуу талаар өнгөрч болно”;

11.4.2. хоёр удаагийн богино дуут дохио нь “Та миний баруун хажуу талаар өнгөрч болно”;

11.4.3. гурван удаагийн богино дуут дохио нь “Би ухарч байна” гэсэн дохио;

11.4.4. хэрэв санал болгосон маневрыг нь нөгөө усан замын тээврийн хэрэгслийн удирдлага зөвшөөрсөн бол ижилхэн дуут дохио өгнө.

11.5. Үзэгдэх орчин хязгаарлагдсан, манан будан дунд усан замын тээврийн хэрэгслийн дуут дохиог сонссон ч түүнийг олж харахгүй байгаа бол мөргөлдөх аюул эрсдэл байхгүй байна гэдэгт бүрэн итгэх хүртлээ хамгийн бага хурдаараа урагшилна. Үүнд:

11.5.1. хүч дамжуулах удирдлагатай усан замын тээврийн хэрэгсэл усан замд яваа үедээ нэг урт дуут дохиог хоёр минут тутамд өгнө;

11.5.2. дарвуулт усан замын тээврийн хэрэгсэл, усан замд яваа үедээ нэг урт, хоёр богино дуут дохиог хоёр минут тутамд өгнө;

11.5.3. хүч дамжуулах удирдлагатай замд яваа усан замын тээврийн хэрэгсэл түр зогсох үедээ хоёр урт дуут дохиог хоёр минут тутамд өгнө;


11.5.4. зангуутай зогсож буй усан замын тээврийн хэрэгсэл хонхоо 5 секунд хурдтай жингэнүүлэн цохисон дуут дохиог нэг минут тутамд өгнө;

11.5.5. хайрдсан усан замын тээврийн хэрэгсэл хонхоо гурван удаа цохиж, түүнийг 5 секунд хурдтайгаар жингэнүүлэн дуугаргаж, хонхоо дахин гурван удаа цохисон дуут дохиог нэг минут тутамд өгнө.

11.6. Анхааруулах болон болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байлгах дуут дохио өгөх:

11.6.1. зогсоолоос хөдлөх, эсвэл ус руу түрж орсон уулын далдлагдсан хошуу, хясаа, нуранги овгор элс, усан дорх хад чулуу мэтийн саад тойрох үед нэг урт дуут дохио өгнө;

11.6.2. аюул ослын үед, эсвэл үл ойлгох, эсвэл бусад жолооч нарын маневр, зорилгыг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлэхэд тав, түүнээс олон удаа ойр ойрхон хурдан давтамжтай богино дуут дохиог хэрэглэнэ.



12. Дуут дохио өгөх төхөөрөмж, хэрэгслийг хэрэглэх

44

12.1. усан замд хөвж буй бүх усан замын тээврийн хэрэгсэл, усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгсэл дуут дохио өгөх дараах төхөөрөмж, хэрэгсэлтэй байна. Үүнд:

12.1.1. жижиг оврын усан замын тээврийн хэрэгсэл, түүний дотор усны мотоциклд дуут дохио өгөх төхөөрөмж, хэрэгслийг суурилуулахыг шаардахгүй /гэхдээ авч явахыг зөвлөмж болгодог/;

12.1.2. бага оврын усан замын тээврийн хэрэгсэл дээр доод тал нь 900 м-ээс 1,6 км хүртэл зайд сонсогдох аман болон гар бариултай, эсвэл зайгаар ажилладаг шүгэл, хонх, сигнал болон бусад төхөөрөмж, хэрэгслийн аль нэгийг авч явна;

12.1.3. дунд оврын усан замын тээврийн хэрэгсэл дээр 1.6 км хүртэл зайд сонсогдох шүгэл, сигнал, хонхны аль нэгийг авч явна.

13. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд туслах тэмдгүүдийг таних, хэрэглэх

13.1. Хөвөгч цамхаг болон тэмдгүүд нь "усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн гэрэл дохио" бөгөөд усны мандлын зарим нэгэн хэсгээр аюулгүйгээр хөвөх, нэвтрэхэд усан замын тээврийн хэрэгслийн жолооч нарт хөтөч болдог. Эдгээр тэмдэг нь усан замын аюултай хэсгүүд, хязгаарлалт, хяналтын бүсийг мэдэх, мөн хөвөлтийн чиглэлүүдийг зааж, мэдээлэл өгдөг. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд туслах **хажуугийн** болон **хөндлөнгийн** тэмдгүүдийг мэдэж байх үүрэгтэй.

13.2. Хажуугийн /латерал/ тэмдгүүдийг хэрэглэх


13.2.1. усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд туслах эдгээр тэмдгийг усан орчин ба эрэг хоорондох аюулгүйн хязгаарыг зааглаж усны захад байрлуулдаг; Жишээлбэл, суваг доторх аялалын чиглэлийг заах г.м. Эдгээр тэмдгийг тоо болон өнгөтэй хослуулж хэрэглэх бөгөөд хөвөгч цамхаг-шон бүрт болон байнга суурилуулсан тэмдгүүд дээр тоо, өнгө бичдэг.

13.3. Тэмдгийн өнгө болон тоогоор илэрхийлсэн утга


13.3.1. хөвөгч шон цамхаг буюу тэмдгийн хэлбэр, загвараас үл хамааран дээр нь бичигдсэн өнгө болон тоонууд нь адил утгыг илэрхийлнэ;

13.3.2. **улаан өнгө /өдрийн цагт/, улаан гэрэл /шөнө/ болон тэгш тоонууд:** урсгал сөрөх, эсвэл боомт зогсоол руу орж ирэхэд суваг, шуудууны захыг тэмдэглэсэн эдгээр тэмдэг нь усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн баруун гар талд байна. Жолооч урсгал сөрж, эсвэл боомт, зогсоол руу буцаж ирж байгаа учраас тэмдгийн дээрх тоонууд дэс дараалан өснө;

13.3.3. **ногоон өнгө /өдрийн цагт/, ногоон гэрлүүд /шөнө/ болон сондгой тоонууд:** урсгал сөрөх, эсвэл боомт, зогсоол руу орж ирэхэд суваг, шуудууны захыг тэмдэглэсэн эдгээр тэмдгүүд нь усан замын тээврийн хэрэгслийн жолоочийн зүүн гар талд байна. Жолооч урсгал сөрж, эсвэл боомт, зогсоолдоо буцаж ирж байгаа учраас тэмдгийн дээрх тоонууд нь дэс дараалан өснө;



13.3.4. өдрийн тэмдгүүд: Эдгээр тэмдгүүд нь усны ёроолд бат бөх суурилуулсан мод, төмөр бетон шон гэх мэт байгууламжид хөдөлгөөнгүй байрлуулж бэхэлсэн тэмдгүүд юм. Нийтлэг хэрэглэдэг өдрийн тэмдэглэгээ нь улаан гурвалжин болон ногоон дөрвөлжин юм. Мөн эдгээр тэмдгүүд нь гэрэлтдэг байж болно.



13.4. Хөндлөнгийн хөвөгч шон-тэмдгүүдийг таних, ашиглах

13.4.1. усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдалд туслах эдгээр хөвөгч шон-тэмдгүүд нь усан мандал, усан орчны аюулгүйн хязгаарын гадна байгаа бусад мэдээллийг өгдөг. Нийтлэг хэрэглэгддэг зохицуулалтын шон-тэмдэг нь улбар шар будгаар будсан хүрээ, хөндлөн бүслүүр, хар өнгөөр бичсэн мэдээлэл бүхий цагаан өнгөтэй гуалин тэмдэг юм. Эдгээр тэмдгийг нуур, цөөрөм, гол, мөрөнд дараах үйл ажиллагаанд хэрэглэнэ. Үүнд:

- 13.4.1.1. чиглэл заах болон мэдээлэл өгөх;
- 13.4.1.2. саад тотгор, аюулаас урьдчилан сэргийлж анхааруулах;
- 13.4.1.3. хяналтад байгаа бүс, усан мандал, орчныг тэмдэглэх;
- 13.4.1.4. онцгой буюу хаалттай бүсийг тэмдэглэх.

13.5. Мэдээлэх

13.5.1. дээд, доод хоёр үзүүрээс нь тодорхой зайнд улбар шар өнгийн хөндлөн бүслүүртэй гуалин шон хэлбэрт цагаан өнгийн энэхүү хөвөгч

тэмдэг дээр хоёр бүслүүрийн хооронд улбар шар будгаар зурсан дөрвөлжин дүрс дотор хоол хүнс, түлш шатахууны хангамж, сэлбэг, засвар

үйлчилгээ авах байршил заасан мэдээллийг хар өнгөөр бичсэн байхаас гадна чиглэл, зай болон

бусад зохицуулагдаагүй мэдээллийг



өгнө.

13.5.2. Аюултай бүс заасан тэмдэг

13.5.2.1. дээд, доод хоёр үзүүрээс нь тодорхой зайнд улбар шар өнгийн хөндлөн бүслүүртэй гуалин шон хэлбэрт цагаан өнгийн энэхүү хөвөгч тэмдэг дээр хоёр бүслүүрийн хооронд улбар шар будгаар зурсан ромбо дүрсний дотор усан дорх саад, хад чулуу, элс, хэт гүехэн хэсэг, байгууламж, далан болон модны хожуул гэх мэт аюулаас урьдчилан сэргийлэх мэдээллийг хар өнгөөр



бичиж заасан байна. Аюулгүйн зай барьж маш анхааралтай хөвөлтөө үргэлжлүүлнэ. Аюултай газар, хэсэг бүрийг ийм тэмдгээр тэмдэглэсэн гэж итгэж болохгүй.

13.5.3. Хяналтад байгаа бүс

13.5.3.1. дээд, доод хоёр үзүүрээс нь тодорхой зайнд улбар шар өнгийн хөндлөн бүслүүртэй гуалин шон хэлбэрт цагаан өнгийн энэхүү хөвөгч тэмдэг дээр хоёр бүслүүрийн хооронд улбар шар будгаар дүрсэлсэн дугуй тойрог дотор усан замын тээврийн хэрэгслээр долгион давалгаа үүсгэхгүй явах, бага хурдаар явах, хурд хязгаарласан болон усны нисэх


онгоцны буух талбайг заасан мэдээллийг хар өнгөөр бичсэн байна.



13.5.4. Онцгой буюу хаалттай бүс

13.5.4.1. дээд, доод хоёр үзүүрээс нь тодорхой зайнд улбар шар өнгийн хөндлөн бүслүүртэй гуалин шон хэлбэрт цагаан өнгийн энэхүү хөвөгч тэмдэг дээр хоёр бүслүүрийн хооронд улбар шар будгаар зурсан хэрээсэлсэн ромбо дүрсэн дотор бүх усан онгоц орохыг хориглосон бөгөөд усанд шумбах бүс, далан хаалт, ус

зайлуулагч гэх мэт бүсийг зааж буй мэдээллийг хар өнгөөр бичсэн байна.



13.6. Хөндлөнгийн бусад хөвөгч шон-тэмдгүүдийг таних, ашиглах

13.6.1. Усан замын аюулгүйн бүсийг заагч хөвөгч шон-тэмдэг:

13.6.1.1. босоо улаан судал бүхий цагаан өнгөтэй эдгээр хөвөгч

Эдгээр шон - тэмдэг нь суваг, шуудууны болон гэрэлт замын голыг заах бөгөөд усан замын тээврийн хэрэгсэл аль ч талаар нь өнгөрч болно.




шон-тэмдгүүд нь усан мандал, хүрээлэн буй орчин бүх талаасаа чөлөөтэй байгааг заана.

13.6.2. Усан зам дахь саад, тотгорыг хүрээлсэн хөвөгч шон-тэмдэг

13.6.2.1. босоо хар судал бүхий цагаан өнгөтэй эдгээр хөвөгч шон - тэмдэг нь усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд учрах саад, тотгор, элдэв бэрхшээл байгааг заана. Эргийн ойролцоо болон эдгээр хөвөгч

шон - тэмдгийн дундуур хөвөхийг




хориглоно.

13.6.3. Хөдөлгөөнгүй суурилуулсан шон-тэмдэг

13.6.3.1. эдгээр шон нь хөндлөн хөх бүслүүртэй цагаан өнгөтэй бөгөөд усан замын тээврийн хэрэгсэл зангуутай зогсох боломжгүй зогсоол эсвэл усан орчны бусад бүсүүдэд

замын тээврийн хэрэгслээ хууль ёсоор уяж аргамжиж болох цорын ганц шон



юм.




хэрэглэнэ. Эдгээр нь усан

14. Зангуутай ажиллах, зангууны хэлбэрүүд

14.1. Усны мандал дээр усан замын тээврийн хэрэгсэл эвдрэх буюу өөр бусад саатал гарсан тохиолдолд, мөн аюул ослын үед аврах ажиллагаа явуулах болон усанд шумбах, эсвэл загас агнах үед усан замын тээврийн хэрэгслийг усан



дээр зогсоож зангуугаар аргамжина. Усан замын жижиг оврын тээврийн хэрэгслийн зангуу нь анжис, хүрз, мөөгөн гэсэн гурван хэлбэртэй байна.



14.2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч өөрийн завь болон хөвөх нөхцөлдөө тохирсон зангуу сонгоно. Үүнд:

14.2.1. Анжис хэлбэртэй зангуу нь ихэнх завинд сайн тохирох ба түүний барих, татах хүч нь ёроолын тунадаст шигдэснээр бий болно.

14.2.2. Хүрз буюу тавхай хэлбэртэй зангуу (Danforth нэрээр дэлхий нийтэд тархсан) нь анжис хэлбэрийн зангуутай төстэй ба гэхдээ илүү хөнгөн жинтэй. Энэхүү зангуу нь мөн ихэнх завинд сайн тохирох бөгөөд түүний барих, татах хүч нь ёроолын тунадасыг хүрзээр ухаж байгаа мэт тогтосноор бий болно.

14.2.3. Мөөгөн хэлбэрт зангуу нь ёроолын тунадаст гүн шигдэснээр түүний татах, барих хүч үүсдэг. Энэхүү зангууны барих, татах хүч нь сул учир зугаалгын жижиг завь, жижигхэн дарвуулт завь болон хийлдэг завиас бусад том завиудад хэрэглэж болохгүй. Ширүүн урсгал, давалгаатай усанд буюу цаг уурын тааламжгүй нөхцөлд завиа хэзээ ч мөөгөн зангуугаар аргамжиж, түүнээс хамаарч болохгүй.

14.2.4. Ачих буулгах налуу зогсоолын бүс, эсвэл хөвөлтийн өндөр нягтралтай бусад дурын бүсүүдийн дотор болон суваг, шуудуугаар дамжин өнгөрөхөд саад тотгор учруулахаар зангуугаа буулган зогсож болохгүй.

15. Луужин, газрын зураг ашиглах

15.1. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, ахмад, жолооч нь луужин, усан замын газрын зурагтай байж, усан онгоц, завь зүг чигээ алдсан, үзэгдэх орчин хязгаарлагдсан, манан будантай, цаг агаарын хүнд нөхцөл, эрэг харагдахгүй байгаа үед усан замын тээврийн хэрэгслээ газрын зураг, луужингаар удирдах, чиглүүлэх чадвартай байна.

15.2. Луужинг төмөр, соронзон, цахилгааны утас болон цахилгааны тоног төхөөрөмжөөс хол суурилуулна. Хойд зүгийг бодитой тодорхойлохын тулд луужингийн заалтын хазайлт /гажилт/ -ыг тооцно.


15.3. Усан замын тээврийн хэрэгслийн луужин, удирдлага, жолоодлогын бусад тоног төхөөрөмжүүдээр цаг агаарын тааламжтай нөхцөлд дадлага хийж, баталгаатай ашиглаж чадаж байна уу, үгүй юу гэдгээ байнга шалгана.

15.4. Усан замын газрын зураг нь усны гүн, далан, суваг шуудууны байршлууд, элсэн зурвас далан, ургаа хад чулуу болон өвс ургамал мэтийн чухал мэдээллүүдийг агуулдаг ба хамгийн дөт чиглэлээ сонгож түлш шатахуунаа хэмнэх боломж олгоно.

16. Хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгсэл (цаашид “Аврах хантааз” гэх)-ийг сонгох, хэрэглэх


16.1. Аврах хантааз нь дараах үндсэн дөрвөн төрөл, загвартай байна. Үүнд:

16.1.1. I загвар: эргээс алс хол зайд өмсөх аврах хантааз - эх газраас алслагдсан зайд хүчтэй салхи, шуурга, ширүүн давалгаа зэрэг цаг уурын хүнд нөхцөлд, тодорхой цаг хугацаа шаардсан аврах ажиллагаанд зориулагдсан аврах хантааз;



Type I

16.1.2. II загвар: эрэг орчимд өмсөх аврах хантааз – намуун, тогтуун, давалгаагүй усанд даруй тусламж үзүүлэх болон аврах ажиллагааг яаралтай хэрэгжүүлэхэд зориулагдсан жилет, майка хэлбэртэй аврах хантааз;



Type II


16.1.3. III загвар: усан дээр хөвөхөд туслах хэрэгслүүд - намуун, давалгаагүй усанд нэн даруй тусламж үзүүлэх болон аврах ажиллагааг нэн яаралтай хэрэгжүүлэхэд зориулагдсан жилет, майка хэлбэртэй аврах урт ханцуйт (хийлэгддэг) хантааз;



Type III inflatable




Type III




52

16.1.4. IV загвар: шидэж өгөх зориулалттай аврах хэрэгслүүд – усанд унаж золгүй явдал учирсан хэн нэгэнд шидэж өгөхөд зориулагдсан хөвөгч дэр ба аврах цагирагууд;



Type IV Cushion



Type IV Ring Buoy

16.1.5. V загвар: Тусгай зориулалтын аврах хэрэгслүүд - далай, тэнгисийн салхи, давалгаанд дарвуулт завь, спортын бусад хөвөгч хэрэгслээр зугаацах, усны мотоцикл, цанаар гулгах, каяк, хөнгөн завиар аялах зэрэгт зориулагдсан жилет, майка, усны костюм, хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгслийн хослол ба бусад хөвөгч хэрэгслүүд.



Type V

16.2. Усан замын тээврийн бүх төрлийн хөвөгч хэрэгсэл (түүний дотор хөдөлгүүргүй усан онгоц, завь, хөвөгч хэрэгсэл) олон улсын жишигт нийцсэн I, II ба III загварын аврах хантаазын аль нэг загварынхаас нь тавцан дээрх хүн нэг бүрт хүрэлцэхүйц тоогоор хангагдсан байна. Аврах хантаазын төрөл, тоо ширхэг нь усан онгоц, завь, усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгслийн урт, түүний дээр зорчиж буй хүмүүсийн тооноос хамаарна. Үүнд:

16.2.1. жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслүүд I, II ба III загварын аврах хантаазны аль нэг загварын шаардлагыг хангахаас гадна IV загварын (шидэж өгөх) нэг аврах цагираг, эсхүл хөвөгч дэрийг тавцан дээрээ авч явна. Хөдөлгүүргүй усан онгоц, завь, хэрэгслийг IV загварын (шидэж өгөх) нэг аврах цагираг, хөвөгч дэрийг тавцан дээрээ авч явахаас чөлөөлнө;

16.2.2. жижиг, бага оврын усан замын тээврийн хэрэгслийн тавцан дээр байгаа буюу аялж буй бага насны (16 хүртэлх) хүүхдэд олон улсын жишигт нийцсэн I, II буюу III загварын аврах хантаазыг өмсгөнө;

16.2.3. усны мотоцикл, цана, сэлүүрт болон дарвуулт завь бусад хөвөгч хэрэгсэл, төхөөрөмжөөр зугаацаж буй хүн нэг бүр олон улсын жишигт нийцсэн I, II, III загварын болон V загварын аврах хантаазыг өмсөнө;

16.2.4. чирч, чирүүлж буй усан замын тээврийн хэрэгслийн ар хэсэгт ажиллаж буй хүн бүхэн олон улсын жишигт нийцсэн I, II буюу III загварын хувийн хамгаалалтын хөвөгч хэрэгслийг өмсөнө.

16.3. Аврах хантааз нэг бүр нь эдэлгээ даах сайн чанартай, түүнийг өмсөх хүний биеийн хэмжээнд яг таарч тохирсон байх ба аврах хантаазны хэмжээг тухайн хүний биеийн жин, цээжний тойрогыг үндэслэн тохируулна.

16.4. Аврах хантаазыг нэн даруй шүүрэн авахад бэлэн газар хадгална. Цоожтой хайрцаг саванд, гялгар уут, хуванцар саванд хийх, мөн бусад тоног төхөөрөмж, хэрэгслийг дээр нь тавьж хадгалж болохгүй.

16.5. Усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, ахмад, жолооч бүр өөрийн тээврийн хэрэгслээр усан орчинд зорчиж буй хүн бүрийг аврах хантааз өмсөхийг шаардана.

17. Галын хор, гал унтраагуурыг ашиглах

17.1. Хүч дамжуулах удирдлагатай бага оврын усан замын бүх тээврийн хэрэгсэл нь бензин, түлш мэтийн шатамхай шингэн бодисуудаас үүссэн /В төрлийн/ галыг унтраах гал унтраагуур, галын хорыг тавцан дээрээ авч явна.

17.2. Хүч дамжуулах удирдлагатай жижиг оврын усан замын бүх тээврийн хэрэгсэл, түүний дотор усны мотоциклд, хэрэв дараах нөхцлүүдээс аль нэг нь, эсхүл хэд хэд нь үүсэхээр байгаа бол, бензин, түлш мэтийн шатамхай шингэн бодисуудаас үүссэн /В төрлийн/ галыг унтраах гал унтраагуур, галын хорыг тавцан дээрээ авч явна. Үүнд:

17.2.1 хаалттай, битүү өрөө тасалгаанд;


17.2.2 хөдөлгөөнгүй суурилуулсан түлш, шатахууны саванд;

17.2.3 усан замын тээврийн хэрэгслийн их биед хөдөлгөөнгүй бэхлэгдээгүй буюу хөвөгч материалаар бүрэн гүйцэд чигжээгүй давхар ёроолд;

17.2.4 хүн амьдардаг хаалттай, битүү өрөө, орон зайд.

17.3. Галын хор, гал унтраагуурыг хэрхэн ашиглаж хэрэглэх мэдлэгтэй байхаас гадна нэн даруй хүрч, авахад хялбар байрлалд байрлуулах ба хаалттай өрөө, тасалгаанд болон хөдөлгүүртэй ойр байрлуулж болохгүй.

17.4. Галын хор, гал унтраагуур нь дараах нөхцлийг хангаж буй эсэхийг байнга шалгана. Үүнд:



- 17.4.1. лац, ломбо, цоожлогчийн үзүүлэлтийг заагч /хянах самбар/ нь алга болоогүй буюу хагараагүй байх;
- 17.4.2. даралт хэмжигч буюу заагч нь заах хэмжээ, эгнээндээ байх;
- 17.4.3. ямар нэгэн механик гэмтэл, зэврэлт, гоожилтгүй болон яндан хоолой нь хог шороогүй байгаа эсэх.

18. Усан замын тээврийн хэрэгслийн ослын үед авах арга хэмжээ

18.1. Усан замын тээврийн хэрэгслийн осол гарсан үед бусад усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, ахмад, жолооч дараах арга хэмжээг авна. Үүнд:

18.1.1. ослын газар дээр өөрийн усан замын тээврийн хэрэгсэл, усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгслийг нэн даруй зогсоох;

18.1.2. ослын улмаас живэх аюулд орсон болон бэртэж гэмтсэн хүнд, өөрийн усан замын тээврийн хэрэгсэл, усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгсэл, зорчигчдыг ноцтой аюулд учруулахгүйгээр туслах;

18.1.3. бэртэж, гэмтсэн хүнд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, өөрийн нэр, хаяг, усан замын тээврийн хэрэгсэл, усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгслийн дугаарыг өгч, ослын улмаас эвдэрч гэмтсэн, живсэн эд хөрөнгийн талаар эзэнд нь амаар болон бичгээр мэдэгдэнэ.

18.2. Осолдсон усан замын тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, ахмад жолооч дараах тохиолдолд ослын талаар орон нутгийн ОБГ, Цагдаагийн газарт мэдээлнэ. Үүнд:

18.2.1. хүний амь нас үрэгдсэн буюу сураггүй алга болсон;


18.2.2. хүн бэртэж гэмтсэн, эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлсний дараа түүнд эмнэлгийн тусламж шаардлагатай бол;

18.2.3. усан замын тээврийн хэрэгсэл бүрэн живж алга болсон, үнэ бүхий бусад өмч хөрөнгө эвдэрч, хэмхэрсэн, живж алга болсныг.

18.3. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь хүний амь үрэгдсэн, хүн сураггүй алга болсон, хүний шарх, бэртэл гэмтэлтэй холбоотой тохиолдолд осол, зөрчлийн тайлан илтгэлийг 24 цагийн дотор гаргаж орон нутгийн ОБГ, Цагдаагийн газарт хүргүүлнэ. Өмч, хөрөнгөтэй холбоотой осол, зөрчлийн тайлан илтгэлийг осол зөрчил болсон өдрөөс хойш 5 өдөрт багтаан хийж орон нутгийн ОБГ, Цагдаагийн газарт хүргүүлнэ.

19. Аюул, осолд орсныг илэрхийлэх ил харагдах дохио, тэмдгүүдийг таних, ашиглах

19.1. Усан замын тээврийн хэрэгсэл аюул осолд орсныг илэрхийлэх ил харагдах дохио, тэмдгүүдийг онцгой байдал /цаашид "аюул ослын" гэх/ үүссэн үед тусламж дуудахад хэрэглэнэ. Аюул ослын дохио, тэмдгүүдийг өдрийн, шөнийн, өдөр-шөнийн дохио, тэмдгүүд гэж ангилах ба дарь (утаа ба гал гаргадаг) -тай буюу дарь (үл шатах) -гүй гэсэн 2 төрөл байна.





Улаан шар утаат
Өдрийн дохио



Улаан оч цацруулагч
Өдөр ба шөнийн дохио



Улаан пуужин
Өдөр ба шөнийн дохио

19.2. Усан орчинд аливаа үйл ажиллагаа явуулж буй усан замын бүх тээврийн хэрэгслүүд төрөл, загвар болон уртаасаа үл хамааран аюул ослын олон улсын жишигт нийцсэн дохио, тэмдгийг нар шингэхээс нар мандах хүртэл хугацаанд тавцан дээрээ байнга авч явна.

19.3. Аюул ослын дохио, тэмдгүүдийг дараахь хослуулсан хэлбэрээр олон улсын жишиг, шаардлагаар усан замын тээврийн хэрэгсэл дээр авч явна. Үүнд:

19.3.1. авч явахад зориулагдсан авсаархан, бариултай улаан пуужин гурван ширхэг (өдөр ба шөнийн);

19.3.2. авч явахад зориулагдсан авсаархан, бариултай улаан пуужин нэг ширхэг, хоёр ширхэг улаан оч цацруулагч дохио (өдөр ба шөнийн);

19.3.3. авч явахад зориулагдсан авсаархан, бариултай улаан шар утаат дохио (өдрийн), улбар шар утаат хөвөгч дохио хоёр ширхэг (өдрийн) ба гар чийдэн, цахилгаан гэрэл (зөвхөн шөнө).

19.4. Аюул ослын дохио, тэмдгүүдийг үйлчилгээний хэвийн нөхцөлд, авахад хялбар газар байлгана. Дарьтай дохио, тэмдгүүдийг ашиглах бол хэрэглэх огноо, хүчинтэй хугацааг анхаарах ба хугацаа дууссан бол тавцан дээрээ авч явахгүй.


19.5. Усан онгоц, завь, хэрэгсэл, тэдгээрийн дээр байгаа зорчигчдод бодитой аюул учирсан, түүнээс нэн яаралтай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах болон усан дээр яаралтай тусламж шаардлагатайгаас бусад тохиолдолд аюул ослын дохио, тэмдгүүдийг хэрэглэж болохгүй.

20. Аюул ослын тусламж дуудах ил харагдах дохио, тэмдгүүдийг таних, хэрэглэх

20.1. Улаан шар дарцаг (өдрийн дохио): аюул ослын тусламж дуудах дарцаг нь 90х90 см-ийн хүртэл хэмжээтэй, улаан шар дэвсгэр дээр хар дөрвөлжин болон дугуй дүрс байна;

20.2. Гар чийдэн /цахилгаан гэрэл/ (шөнийн дохио): аюул, ослын тусламж дуудах цахилгаан гэрэл болон гар чийдэнг шөнийн цагаар хэрэглэх ба аюул ослын олон улсын дохио SOS-ийг автоматаар өгч анивчиж байх ёстой;

20.3. Гараар өгөх дохио: энэхүү дохио нь аюул ослыг илтгэх ил харагдах дохио, тэмдэг, хэрэгслүүдэд тавигддаг шаардлагыг хангахгүй боловч, аюул, ослын ямар ч дохио, тэмдэг байхгүй үед гараа алдлан даллаж тусламж дуудна.



21. Усан дор гүний шумбагч байгааг зааж буй дарцагуудыг таних, хэрэглэх

21.1. Усны тусгай хувцас, акваланг хэрэглэн усны гүнд шумбаж байгаа, усны гүнд жадаар загас агнаж буй болон эрэл хайгуул хийж буй этгээдүүд гүний шумбалт хийж буй бүсээ тэмдэглэж усан дор хийж буй үйл ажиллагаагаа илэрхийлэхдээ дараах 2 төрлийн дарцаг хатгах үүрэгтэй. Үүнд:

21.1.1. диагоналиараа ташуу цагаан зурвастай, тэгш өнцөгт улаан



дарцагыг дотоодын усанд;

21.1.2. олон улсын хууль тогтоомжийн дагуу бүх чиглэл, бүх талаас



харагдах цагаан – цэнхэр өнгөтэй, доод тал нь 1 м хүртэл өндөртэй А дарцагыг тухайн үйл ажиллагааг хэрэгжүүлж буй усан онгоц, завь, хөвөгч хэрэгсэл дээр мандуулна.

21.2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь усан дор гүний шумбалт хийж буйг заасан дарцагыг харвал хурдаа багасгаж “давалгаа үүсгэхгүй хурд”-аар явах ба дарцагаас хол зайтай зогсоно.

22. Усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгсэлд тавих тусгай шаардлага

22.1. Усны мотоцикл нь - хөдөлгүүрээ их бие дотроо агуулсан усан замын тээврийн хэрэгсэл тул жолооч нь бусад усан замын тээврийн хэрэгсэлд тавигддаг шаардлага, дүрмийг нэгэн адил баримталж, дагаж мөрдөхөөс гадна усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгслийн жолооч нарт зориулсан нэмэлт, тусгай дүрэм, журмыг дагаж мөрдөнө. Үүнд:

22.1.1. усны мотоцикл, бусад хөвөгч хэрэгслээр зугаацаж буй хүн бүр эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрсөн I, II, III, буюу V загварын аврах хантаазыг заавал өмсөх;

22.1.2. асаах түлхүүр нь хамгаалалтын сунадаг уяагаар тоноглогдсон усны мотоциклийн жолооч нь хамгаалалтын тэрхүү уяагаа өөрийн биед эсвэл аврах хантаазандаа бэхлэх.

22.2. Усны мотоциклээр дараах бүсүүдээс 30м-ийн дотор “удаан, долгион үүсгэхгүй хурд” -аар явна. Үүнд:

22.2.1. эрэг, эрэг орчимд загас агнаж буй загасчнаас;

22.2.2. усанд сэлэгчээс;

22.2.3. сал, хийлдэг завин дээрээс усанд сэлэх буюу гүний шумбалт хийж буй этгээдээс;

22.2.4. хөдөлгүүргүй усан онгоц, завь, хэрэгсэл болон зангуу хаяж зогссон усан онгоц, завь, хэрэгсэл байрласан бүсээс.

23. Усны мотоциклийн жолоочийн анхаарах зүйлс

23.1. Дараах байдлаар бусдын амь нас, өмч, хөрөнгө, байгаль орчинд аюул занал учруулж болзошгүйгээр усны мотоциклийг үл жолоодно. Үүнд:

23.1.1. усны мотоциклээр хөвөлтийн ачаалал, нягтрал ихтэй усан замыг хэрэн сүлжиж давхих;

23.1.2. мөргөлдөж болзошгүйгээр ойртож ирээд, хамгийн сүүлчийн агшинд нь бултан зайлах; тээврийн хэрэгслийнх нь дэргэдүүр усны мотоциклээр хэт ойрхон тасралтгүй давхиж, усан замын бусад тээврийн хэрэгслийн жолооч нарт сэтгэл зүйн дарамт үзүүлэх;

23.1.3. өөр бусад усан онгоц, завь, хэрэгслийн ар талаас үүсч буй усан боргио, давалгаан дээгүүр тухайн усан онгоц, завь, хэрэгслээс 30 м-ийн дотор харайх;

23.1.4. ухаалаг бус, зөвтгөж болшгүй бусад аливаа хэлбэрээр усны мотоцикл жолоодох;

23.1.5. усны мотоциклийн долгион, давалгааны усаар бусдыг шүршиж, цацах;

23.1.6. амралт, сувилалын болон хүн ам оршин суугаа бүс нутагт, шөнийн цагаар болон нэн ялангуяа өглөө эрт усны мотоциклээр хэт чанга дуу чимээ, шуугиан гарган давхиж, эрэг дээр болон ойр орчинд амарч буй хүмүүсийн амгалан тайван байдлыг алдагдуулах;

23.1.7. мотор/хөдөлгүүрийн янданг усны мандлаас дээшээ цухуйн гаргаж орилуулах үйлдэл /маневр/- хийх;

23.1.8. мотор/хөдөлгүүрийнхээ янданг өөрчилж дуу, чимээ, шуугианыг ихэсгэх;

23.1.9. усны мотоциклийн хий хуваарилах, ачаалах /хааз/ механизмын аливаа нэг хэсгийг өөрчлөх, авч хаях эсхүл жолооч хаазаа хасахад хүлээх горим /нармаал/-д буцахаас сэргийлж өөрчлөлт оруулсан усны мотоцикл жолоодохыг;

23.1.10. усны ан амьтдыг үргээх, элдэн хөөх, усан мандал дээр хөвж байгаа болон усан дор ургасан ургамал дээгүүр хурдтай давхиж байгалийн тэнцвэрт байдлыг алдагдуулах.


24. Усан замын тээврийн хэрэгслээс усан мандлыг хог хаягдал, тосоор бохирдуулахаас сэргийлэх, хог хаягдлыг зайлуулах

24.1. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь усан мандалд хог, тос шатахууны үлдэгдэл болон бусад элдэв хаягдлыг усан замын тээврийн хэрэгслээс хаяхыг хориглох ба тос шатахууны үлдэгдэл, хог хаягдлаа зөвшөөрөгдсөн газарт хүргэж зайлуулах үүрэгтэй.

24.2. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч нь усан мандал, орчныг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх дараах арга хэмжээ авна. Үүнд:

24.2.1. аялалын хугацаанд усан замын тээврийн хэрэгслийнхээ тавцан дээр тусгай контейнерт хатуу хог хаягдлаа хадгалж, эрэг дээр буцаж ирэхдээ түүнийг зөвшөөрөгдсөн газарт хүргэж зайлуулах;

24.2.2. аялал зугаалгын усан замын тээврийн хэрэгслүүд дээр тос, шатахууны үлдэгдэл, хог хаягдлаа зөвшөөрөгдсөн газарт хүргэж зайлуулах хүртлээ хадгалах зориулалтаар хувин, сав авч явах;



24.2.3. усан замын тээврийн хэрэгслийнхээ ёроолд асгарсан тос, шатахууны үлдэгдлийг шингээгч хөвөн даавуун материалаар цэвэрлэх;

24.2.4. хатуу хог хаягдал хаяж болохгүй тухай санамжийг 12 х 20 см хэмжээтэй бат бөх /хөнгөн цагаан/ материалаар хийсэн ялтас дээр бичиж, хөдөлгүүрийн өрөөнд болон зорчигчдын нүдэнд ил харагдах газар, мөн усан замын зогсоол дээр байрлуулах;

24.2.5. усан мандал, усан орчинд усан замын тээврийн хэрэгслээс тос, шатахуун болон бусад аюулт бодис асгарсан тохиолдолд тухайн газрын байршил, өнгө, эх үүсвэр, аюулт бодисын төрөл, хэмжээ болон цаг хугацааг нэн даруй зохих газар /ОБЕГ/-т мэдэгдэнэ.

25. Усан замын тээврийн хэрэгслийн тавцан дээрээс хог хаягдлыг зайлуулах заавар

25.1. Бага, дунд оврын, гал зуухны болон унтлагын өрөөний тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 1-ээс дээш хоног усан орчинд аялах зориулалттай усан замын тээврийн хэрэгслүүдэд хог хаягдлаа зайлуулах зааврыг бичгээр үйлдэнэ.

25.2. Хог хаягдал зайлуулах зааварт усан замын тээврийн хэрэгслийн нэр, боомт болон тээврийн хэрэгслийн тавцан дээрх бүх хүмүүс юу хийхийг нэг бүрчлэн заасан удирдамж агуулсан байх ба зорчигчдод ил харагдах газарт байрлуулсан байна. Тухайлбал:

25.2.1. бохир ус ба бусад аюулт бодисыг хэрхэн хаях;

25.2.2. хатуу хог хаягдал ба хүнсний үлдэгдэл хаягдлыг хэрхэн хаях;

25.2.3. хуванцар, архи ундааны шилэн сав, лаазуудыг хэрхэн зайлуулах;

25.2.4. бусад нэмэлт мэдээллийг хаанаас авах;

25.2.5. дизель тос буюу бензин, шатахуун асгарсан тохиолдолд жолоочид мэдээлэх.

25.3. Усан замын тээврийн хэрэгслийн жолооч хог хаягдал зайлуулах зааврын хэрэгжилтийг хянана.

26. Усны түвшин өөрчлөгдөх

26.1. Усны таталт, түрэлт, гол мөрний үерлэсэн ус, эсвэл далан хаалтаас чөлөөлөгдөж тавигдсан ус зэргээс шалтгаалж усны түвшин өөрчлөгдөнө. Үүний улмаас урьд өмнө нь усан замын хөвөлтөд аюул, осолгүй байсан газар, бүст усан замын тээврийн хэрэгслийг хайрдуулж болно.

26.2. Усны таталт, түрэлт нь өдөрт хоёр удаа, ойролцоогоор 6 цагийн зайтайгаар болдог. Мөн усны түвшингийн аливаа өөрчлөлт нь хөдөлгөөнгүй суурилагдсан усан замын тээврийн хэрэгслийн зогсоол болон засварын зогсоолд зогсоход хүндрэл учруулдаг.

27. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлага

27.1. Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрмийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийг Усан замын тээврийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

**“Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм”-ийн
төсөлд хийсэн нөлөөллийн шинжилгээ**

2017.12.06

1. Дүрэм батлуулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын томоохон гол, мөрөн, нууруудад тун цөөхөн, түүний дотор Хөвсгөл нуурт 2000 оны дундуур иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 10 хүрэхгүй усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр 80 гаруй болж цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай болж байгаа ба үүнтэй уялдан усан замын тээврийн зорчигч тээвэрлэлт өсч, 2002 оны үед жилдээ 6000 орчим зорчигч тээвэрлэж байсан бол сүүлийн 5 жил /2012-2017/-ийн дунджаар 57000 орчим зорчигч тээвэрлэж байна.

Зорчигч тээвэрлэлт ийнхүү өссөн нь усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх харилцааг зохицуулсан, зорчигч, тээвэрлэгч, ачаа илгээгч, ачаа хүлээн авагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тогтоосон дүрэм боловсруулах, батлуулан мөрдүүлэх шаардлага гарч байна.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны хаврын чуулганаар Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн баталсан. Энэхүү хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5. “тээвэрлэлтийн үйл ажиллагаа, усан замын тээврийн хэрэгсэл, усан замын төв буудал, зогсоол, аврах хэрэгсэл, тоног төхөөрөмжийн техник ашиглалтын талаар нийтлэг мөрдөх дүрэм, журам, норм, нормативыг батлах...”, 11 дүгээр зүйлийн 11.2-т “Усан замын тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заасныг тус тус үндэслэн энэхүү дүрмийг шинээр боловсруулж усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар батлуулна.

2. Дүрмийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ


Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөвөлтийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааг нь гол, мөрөн, нуурын экологи, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байлгахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3. Дүрмийн төсөл батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Дүрмийн төсөл батлагдсаны дараа усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд




суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү, эдийн засгийн тооцоо.

Дүрмийн төсөлд тусгагдсан харилцааг өмнө нь Зам, тээврийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 275 дугаар тушаалаар баталсан "Усан замын тээврийн хэрэгслээр ачаа болон зорчигч тээвэрлэх дүрэм"-ээр зохицуулахыг оролдсон ч "хууль тогтоомжийн зүйл заалтыг хуулбарлан давхардуулахгүй байх, шаардлагатай гэж үзвэл ишлэл хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх"; "хуульд заагаагүй үүргийг шинээр бий болгохгүй байх" гэж заасан шаардлагуудыг хангаагүй гэж Хууль зүйн яамнаас үзэж, дүгнэлт ирүүлснээр уг дүрэм хүчин төгөлдөр болоогүй юм.

Тавигдаж буй шаардлагын дагуу дүрмийг шинээр боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, санхүү, эдийн засгийн зардал гарахгүй болно.

САЙД  Ж. БАТ-ЭРДЭНЭ



ТАНИЛЦУУЛГА

Манай Улсад усан замын тээвэр 1950-иад оноос үүсэн хөгжиж ОХУ-аас импортолж буй өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал бусад ачааг 1 чирэгч хөлөг онгоц, 3 чиргүүл /нэг нь шингэн ачааны/ онгоцоор Ханх, Хатгал боомтын хооронд Хөвсгөл нуураар тээвэрлэхийн зэрэгцээ Ханх сум, Хатгалын хооронд алба, амины ажлаар явж буй хүмүүсийг ч мөн тээвэрлэж байв.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 1990-ээд оноос хойш ОХУ-аас импортлох барааны ачаа эргэлт үгүй болсон, мөн байгаль орчны асуудлаас болж усан замын тээвэр зогссон юм.

Өнөөгийн байдлаар усан замын тээврийн үйлчилгээг хувийн хэвшлийнхэн буюу иргэн, аж ахуйн нэгжүүд ихэвчлэн аялал жуулчлалын зориулалтаар эрхэлж жижиг, бага оворын усан замын тээврийн хэрэгслүүдээр амрагч, жуулчдыг тээвэрлэж байна.

Эдгээр хөдлөх бүрэлдэхүүний загвар хуучирсан, техникийн байдал сайнгүй, хөвөлтийн аюулгүй байдал хангалтгүй, ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай байгаагаас гадна тээвэрлэх ачаа, зорчигч хомсдолтой, үйл ажиллагаа нь улирлын чанартай явагдаж байгаа.

Иймээс усан замын тээврийн салбарын аюулгүй байдлыг хангах, хууль эрх зүйн орчин боловсронгуй болгох бодлогын хүрээнд УИХ-аас 2003 онд баталсан Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж 2017 оны 05 дугаар сарын 25-нд батлуулаад байна.

Усан замын тээврийн тухай шинэчлэн баталсан хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 дахь заалтад "Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм боловсруулж батлуулах"-аар тусгагдсан. Энэхүү заалтын дагуу болон Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн дүрмийн төслийг боловсруулсан ба дүрмийн төсөл батлагдсанаар усан замын тээврийн хэрэгслийн жолооч, ахмад нар хөвөлтийн үед ямар ямар үйлдэл, үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлагын талаар бүрэн дүүрэн мэдлэгтэй болж, улмаар усан замын тээврийн хэрэгслүүд мөргөлдөх, түүний улмаас хүний амь нас, эд хөрөнгө хохирох эрсдэл буурч, хөвөлтийн аюулгүй байдал хангагдана.

"Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм"-ийн төсөлд тусгагдсан харилцааг өмнө нь зохицуулсан ямар нэгэн дүрэм, журам, заавар байхгүй бөгөөд шинэчлэгдэн батлагдсан Усан замын тээврийн тухай шинэчилсэн хуульд заасан тавигдаж буй шаардлагын дагуу дүрмийг шинээр боловсруулсан.

Мөн энэхүү хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь заалтад "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм болон хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасан нь "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"-ийг боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.


Дүрмийн төслийг ОХУ-д хүчин төгөлдөр үйлчилж буй усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрмийг гарын авлага болгон уашигласан бөгөөд Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн бүхэлд нь шинэчлэн боловсруулж, нийтлэг үндэслэл, усан замын тээврийн хэрэгслээр зорчигч тээвэрлэхэд тавигдах

шаардлага, ачаа тээвэрлэхэд тавигдах шаардлага, бусад гэсэн дарааллаар томъёолж, тээврийн дагалдах бичгийн загварын хамт боловсруулсан.

Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хөвөлтийн аюулгүй байдлыг хангах, үйл ажиллагааг нь гол, мөрөн, нуурын экологи, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байлгахтай холбогдсон харилцааг энэхүү дүрмээр зохицуулна.

"Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"-ээр зохицуулагдах харилцааг өмнө нь Зам, тээврийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 275 дугаар тушаалаар баталсан "Усан замын тээврийн хэрэгслээр ачаа болон зорчигч тээвэрлэх дүрэм"-ээр зохицуулахыг оролдсон ч "хууль тогтоомжийн зүйл заалтыг хуулбарлан давхардуулахгүй байх", "хуульд заагаагүй үүргийг шинээр бий болгохгүй байх" зэрэг шаардлагыг хангаагүй гэж ХЗЯ дүгнэлт хийж, буцаан ирүүлснийг анхааралдаа авч, уг дүрмийг дахин шинээр боловсруулан Зам, тээврийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 138 дугаар тушаалаар батлуулан ХЗЯ-нд 02/2429 тоот албан бичгээр улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүргүүлсэн боловч УИХ-ын сонгууль болсон, Засгийн газар шинээр байгуулагдсан, Усан замын тээврийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлуулсан зэрэг шалтгаанаар улсын бүртгэлд хараахан бүртгэгдээгүй тул "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"-ийг дахин шинэчлэн боловсруулав.

--- оОо ---



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 26 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ЗОРЧИГЧ, АЧАА ТЭЭВЭРЛЭХ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

УХА0382
5919487
1116126781

1.1. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх гол, мөрөн, нуурын усанд усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа, тээш тээвэрлэх болон тээвэрлэлтийн харилцаанд оролцогч тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, зорчигч, ачаа хүлээн авагч, түүний төлөөлөл нарын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

1.2. Энэхүү дүрэмд хэрэглэсэн нэр томъёог Усан замын тээврийн тухай хуульд¹ заасан утгаар ойлгоно.

1.3. Усан замын тээвэрлэлтийн нийт үргэлжлэх хугацаа жил бүрийн 06 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдөр хүртэл байна. Энэ хугацааны хязгаарт нийцүүлэн Талууд усан замын тээвэрлэлтийн үргэлжлэх хугацааг гэрээгээр тохиролцоно.

1.4. Усан орчинд зорчигч, ачаа тээвэрлэлт эрхлэх тээвэрлэгч нь усан замын тээврийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг эрх бүхий байгууллагаас авсан байх ба аюулгүй байдлаа хангах үүднээс усан замын тээврийн хэрэгслээ луужин, байршил тодорхойлогч GPS зэрэг тоног төхөөрөмжөөр тоногдосон байна.

Хоёр. Зорчигч тээвэрлэлт

2.1. Тээвэрлэгч нь усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлыг хангаж, зорчигчдыг хүрэх ёстой зогсоолд нь ая тухтай, найдвартай хүргэнэ.

2.2. Тээвэрлэгч нь зорчигчдын тоо, тээш ачих, буулгах ажлын хэмжээнээс нь хамааруулан усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн хуваарь, зогсоолд тээш ачих, буулгах ажиллагаа явуулах журам, цагийн хуваарь гаргаж мөрдөнө.

2.3. Тээвэрлэгч усан замын тээврийн хэрэгслийнхээ хөвөлтийн хуваарь, зорчигч ба тээш тээвэрлэх үнэ өртгийн жагсаалт, тасалбар түгээх, тээш хүлээн авах, олгох цагийн хуваарь болон усан замын тээврийн хэрэгсэлд сул суудал байгаа эсэх тухай болон бусад холбогдох мэдээллээр зорчигчдыг хангана.

2.4. Зорчигчдод тасалбар худалдаалах цагийг усан замын тээврийн хэрэгслийн аялалын хуваарьт нийцүүлэн тогтоож, тэдний овог нэр, холбоо барих утас зэргийг бүртгэж, завсрын болон эцсийн зогсоол хүрэх тасалбарыг худалдаална. Тасалбарын ар талд зорчигчид зориулсан санамж байна.

2.5. Зорчигч нь зорчих тасалбар худалдан авснаар тээвэрлэгчтэй тээвэрлэлтийн гэрээг байгуулсанд тооцно. Тасалбарын загвар, хүчинтэй байх хугацаа, худалдах ба ашиглах заавар болон усан замаар зорчих үед зорчигчдын биеэ авч явах аюулгүйн заавар, журмыг тээвэрлэгч тогтооно.

2.6. Усан замын тээврийн хэрэгслийн зорчигчийн суудлын тооноос илүү тасалбар худалдахыг хориглоно.

¹ Усан замын тээврийн тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 22 дугаарт нийтлэгдсэн

2.7. Тасалбар худалдагч нь дараах тохиолдолд зорчих тасалбар худалдаалахгүй.
Үүнд:

2.7.1. усан замын тээврийн хэрэгсэлд сул суудал байхгүй;

2.7.2. асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй насанд хүрээгүй иргэн, мансууруулах болон согтууруулах ундаа хэрэглэсэн этгээд;

2.7.3. иргэний үнэмлэх, гадаад паспорт, жолооны үнэмлэх зэрэг албан ёсны аль нэг бичиг баримтгүй бол.

2.8. Зорчих тасалбарын хүчинтэй хугацааг дараах тохиолдолд сунгана.

2.8.1. тээвэрлэгчийн буруутай үйл ажиллагаанаас аялал хойшилсон;

2.8.2. аялалын эцсийн зогсоол болон завсрын зогсоолд усан замын тээврийн хэрэгсэл цагтаа хүрэлцэн ирээгүй буюу цагтаа хөдлөөгүй бол саатсан хугацаагаар.

2.9. Зорчигч нь усан замын тээврийн хэрэгсэлд суухдаа зорчих тасалбар, биеийн байцаалтыг хамт шалгуулна.

2.10. Зорчигчийн тээшийг тээвэрлэлтэд хүлээн авсныг баталгаажуулж зорчигчид тээшийн тасалбар олгоно.

2.11. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор усан замын тээврийн хэрэгсэл, түүний дээр байгаа эд хөрөнгө, зорчигчдод хор хохирол учруулж болзошгүй тэсрэх дэлбэрэх ба бусад аюултай бодис, эд зүйлс, бүтээгдэхүүн агуулсан тээшийг энэхүү дүрмийн 2.19-т заасан журмаар тээвэрлэнэ.

2.12. Зорчигч нь 10 кг хүртэл жинтэй гар тээшийг үнэгүй тээвэрлүүлнэ. Зорчигч тогтоосон хэмжээнээс илүү жин, овор хэмжээтэй гар тээш тээвэрлэвэл тээвэрлэгчийн тогтоосон тарифын дагуу нэмэлт төлбөрийг төлнө. Аюулгүй байдлыг хангах зорилгоор зорчигчийн тээшинд хязгаарлалт хийж болно.


2.13. Тусгай суудал эзлэхгүй бол асран хамгаалагч нь 5 хүртэл насны нэг хүүхдийг тасалбаргүйгээр хамт авч явж болно. 5-12 насны зорчигчид хөнгөлөлттэй зорчих тасалбар олгоно.

2.14. Зорчигч нь усан замын тээврийн хэрэгсэл, түүний эд хөрөнгөд ариг гамтай хандаж, олон нийтийн хэв журмыг чанд сахиж, бүх нийтээр дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмыг биелүүлэх үүрэгтэй.

2.15. Зорчигч олон нийтийн хэв журам болон усан замын тээврийн хэрэгсэл дээр мөрдөж буй дотоод журмыг зөрчсөн, бусад зорчигчдын амгалан тайван байдлыг алдагдуулсан, тээврийн хөлс төлөхөөс татгалзсан бол тээвэрлэгч уг зорчигчийг дараагийн зогсоол дээр усан замын тээврийн хэрэгслээс албадан буулгана.

2.16. Зорчигч аялалаас хоцорсон бол тээвэрлэгчээс тогтоосон үйлчилгээний хөлсийг суутгуулж тасалбарын үнийн үлдэх хэсгийг буцаан авна.

2.17. Зорчигч зорчих тасалбараа аялал эхлэхээс 2-оос доошгүй цагийн өмнө буцаавал тасалбарын үнийг эргүүлэн авах, энэ хугацаанаас хожуу боловч усан замын тээврийн хэрэгслийг хөдлөхөөс өмнө тасалбараа буцаавал тээвэрлэгчээс тогтоосон үйлчилгээний хөлсийг суутгуулж, зорчих тасалбарын үнийн үлдсэн хэсгийг буцаан авч болно.



2.18. Усан замын тээврийн хэрэгсэл цагийн хуваариа баримтлахгүй 3 цагаас дээш хугацаагаар хүлээлгэвэл зорчих тасалбарыг буцааж, зорчих тасалбарын үнийг буцааж авна.

2.19. Тээвэрлэгч үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор санал, гомдлын дэвтэр гаргаж, түүний мөрөөр арга хэмжээ авч ажиллана.

2.20. Тээвэрлэгч байгалийн гэнэтийн аюултай үзэгдлийн үед аялалыг цуцлах, хойшлуулах, аялалын эхлэх цаг, очих боомт, зогсоолыг өөрчилж болно.

2.21. Зорчигчоос үл хамаарах шалтгааны улмаас зорчигч аяллын хугацаанд аяллаа зогсоовол зорчоогүй зайн үйлчилгээний хөлсийг тарифын дагуу буцааж олгоно.

Гурав. Ачаа тээвэрлэлт

3.1. Усан замын тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэхтэй холбогдсон харилцааг Иргэний хууль² -ийн 380-398 дугаар зүйлд заасныг үндэслэн зохицуулна.

3.2. Ачааг зориулалтын усан замын тээврийн хэрэгслээр тогтоосон хугацаанд нь тоо чанарыг нь алдагдуулахгүй, хүрэх зогсоолд нь бүрэн бүтэн хүргэж тээвэрлүүлэгч, ачаа хүлээн авагчид хүлээлгэн өгнө.

3.3. Ачааг тээвэрлэлтэд хүлээн авахдаа түүний жинг тодорхойлж тээврийн дагалдах бичигт заана.

3.4. Ачааг бүх төрлийн жин /автомашин, бараа, элеватор, автомат жин/-гээр жинлэнэ. Жин хэмжүүрийн хэрэгсэл нь зохих журмын дагуу баталгаажсан байна.

3.5. Сав, баглаа, боодол дээрээ жинг нь тодорхойлсон ачаа, сав баглаа, боодолгүй ширхэгийн ачаа, түүнчлэн стандарт хэмжээ, жинтэй ачааг тээвэрлэлтэд жинлэхгүйгээр хүлээн авна. Ийм ачааны нийт жинг тээвэрлүүлэгч тодорхойлж тээврийн дагалдах бичигт заана.


3.6. Чингэлэгтэй ачаа болон овор их, хүнд жинтэй ачааг тээвэрлүүлэгчийн тодорхойлсон жин, лацтай тээвэрлэлтэд хүлээн авна.

3.7. Тээвэрлэх явцад эвдэрч гэмтэхээс хамгаалсан зориулалтын сав баглаа боодол шаардагдах ачааг бүрэн бүтэн сав баглаа боодолтой хүлээн авна.

3.8. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, эрүүл ахуй, хорио цээрийн дүрэм, журмын шаардлагад нийцүүлэн, бүрэн бүтэн байдлыг нь хадгалах зориулалтын сав баглаа боодолтой тээвэрлэлтэд хүлээн авна.

3.9. Ачаа ачих эсвэл буулгах зогсоолд усан замын тээврийн хэрэгсэл хүрэлцэн очих цаг хугацааг, хүрэлцэн ирэхээс 2 цагийн өмнө, ачааг ачих буюу буулгахаар усан замын тээврийн хэрэгслийг зогсоолд зогсоох цагийг, түүнийг зогсоолд зогсоохоос 1 цагийн өмнө тээвэрлүүлэгч, ачаа хүлээн авагчид тус тус мэдэгдэнэ.

² Иргэний хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн



3.10. Усан замын тээврийн хэрэгсэл хүрэлцэн ирсэн зогсоолд ачааны хэмжээ, жинг тээвэрлүүлэгч, ачаа хүлээн авагч шалгахдаа анх ачсан зогсоолд ачааны жин, хэмжээ тодорхойлсон аргыг хэрэглэнэ.

3.11. Ачааг усан замын тээврийн хэрэгсэлд бэхлэх бэхэлгээ, тусгаарлагч, жийргэвч ба бусад шаардлагатай материалыг болон тоноглол хэрэгслийг тээврийн дагалдах бичигт заана.

3.12. Тээврийн дагалдах бичигт заасан тээвэрлүүлэгчийн бэхэлгээний материал, тоноглол хэрэгслийг ачаатай хамт хүлээлгэн өгнө.

3.13. Ачаа ачих, буулгах ажлыг усан замын тээврийн хэрэгсэлд эвдрэл, гэмтэл учруулахгүй, ачааны бүрэн бүтэн байдалд нөлөөлөхгүйгээр, хөдөлгөөний болон хөвөлтийн аюулгүй байдлыг хангаж гүйцэтгэнэ.

3.14. Тээврийн дагалдах бичигт ачаа ачсан, буулгасан тухай тэмдэглэл хийж баталгаажуулна.

3.15. Ачаа ачсан усан замын тээврийн хэрэгслүүд, түүний дотор хөргүүртэй болон шингэн тээгч усан замын тээврийн хэрэгслийн агуулах савыг сайтар битүүмжилж, лацдана.

3.16. Тээвэрлэх явцад лац нь хөдөлсөн ачааны болон усан замын тээврийн хэрэгслийн тавцан дээр, эсвэл тавцангүй усан замын тээврийн хэрэгслээр тээвэрлэх үед гэмтэж муудсан шинжтэй ирсэн ачааны жинг тээвэрлэгч болон тээвэрлүүлэгч, ачаа хүлээн авагч хамтран шалгаж хүлээлцэнэ.

3.17. Ачаа хүлээн авагч ачааны тоо ширхэг, жин дутсан, эсвэл сав, баглаа, боодол нь гэмтэж эвдэрсэн байхад өөрөө хүлээн авахыг зөвшөөрвөл ачааг олгож, тээврийн дагалдах бичигт "өөрөө авахыг хүсэв" гэж тэмдэглэл хийж ачаа хүлээн авагчаар гарын үсэг зуруулна.


3.18. Ачааг алдаж үрэгдүүлсэн тохиолдолд Иргэний хуулийн 393.1-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

3.19. Усан замын тээврийн хэрэгслээр газрын тос, шатахуун, байлдааны сум хэрэгсэл, тэсрэх дэлбэрэх, хорт бодис болон бусад аюултай ачааг Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журмын дагуу тээвэрлэнэ.

3.20. Нунтаг, нурмаг, түргэн муудах зэрэг тээвэрлэлтийн тусгай нөхцөл шаардах ачаанд тавигддаг шаардлагыг тээвэрлүүлэгч хангасан байна.

3.21. Усан замын тээврийн хэрэгслийг тухайн төрлийн ачааг тээвэрлэхэд тохиромжтой, цэвэрхэн байлгах бөгөөд ачааг буулгасны дараа цэвэрлэж, шаардлагатай тохиолдолд угааж, хийгүйжүүлж, ариутган халдваргүйжүүлнэ.

Дөрөв. Бусад



4.1. Усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээний чанарт Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Байгаль орчныг

хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хууль, холбогдох бусад хууль, дүрэм, журмын дагуу Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний харъяа байгууллага болон Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын төв орон нутгийн хяналтын улсын байцаагч хяналт тавина.

4.2. Ачаа болон тээш нь гаднаа эвдрэл, гэмтэлгүй бол доторх эд зүйлсийн талаар тээвэрлэгч хариуцлага хүлээхгүй. Тээвэрлүүлэгч нь тээврийн дагалдах бичгээ, зорчигч тээшийн тасалбараа үрэгдүүлсэн тохиолдолд түүний бичгээр гаргасан мэдүүлэг болон бусад холбогдох бичиг баримтыг үндэслэн уг ачаа, тээш нь тухайн тээвэрлүүлэгч, зорчигчийнх мөн болохыг нотлох баталгааг гаргуулж ачаа болон тээшийг олгож болно. Тээвэрлэгч нь энэ тухай тээврийн дагалдах бичигт тэмдэглэл хийж баримтжуулна.


4.3. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч, ачаа хүлээн авагч болон зорчигч энэ дүрмийг зөрчсөн тохиолдолд Усан замын тээврийн тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

4.4. Усан замын тээврийн хэрэгслийн суудлын тооноос илүү тасалбар худалдаалсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу тээвэрлэгчид хариуцлага хүлээлгэнэ.


4.5. Тээвэрлэгчид нь усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн үед гарч болзошгүй техникийн тусламж, туслалцааг харилцан бие биедээ үзүүлнэ.

4.6. Усан замын тээвэрлэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

---- оОо ----



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 12 сарын 21 ны өдрийн 262 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



Зогсоолд ачаа буулахыг зөвшөөрсөн:
20... оны ... сарын ... ны өдөр

Ачаа ачилтыг төвлөсөн:
20... оны ... сарын ... ны өдөр

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ДАГАЛДАХ БИЧИГ

(Хар өнгөөр бөглөх ба баллаж, засахыг хориглоно)

.....
/Ачилтын төрөл/

.....
/Усан замын тээврийн хэрэгсэл, түүний эзэн, жолооч, ахмад/

Тээвэрлэгч 20... " ... "
/гарын үсэг/

Тээвэрлүүлэгч 20... " ... "
/гарын үсэг/

Хөдлөх зогсоол :					Ачааны байршлын тэмдэглэл
Тээвэрлүүлэгч /Ачаа илгээгч/ :					
Албан ёсны хаяг :					
Хүргэх зогсоол :					
Ачаа хүлээн авагч :					Хүрэлцэн ирсэн дугаар
Албан ёсны хаяг :					
Код	Ачааны нэр төрөл	Сав, баглаа, боодол	Тоо ширхэг	Ачааны жин, кг	Таних тэмдэг ба бичлэг
Тоо ширхэг /эзэлж буй байр/ -ийн дүн /бичгээр/					
Ачааны нийт жин /бичгээр/					
Ачааны жинг тодорхойлсон арга:			Ачилт гүйцэтгэсэн хэрэгслүүд:	Ачаа буулгах ажлыг гүйцэтгэсэн хэрэгслүүд:	
Хавсаргасан баримт бичгүүд: 1. 2. 3.					Тээвэрлүүлэгч /Ачаа илгээгч/-ийн гарын үсэг /гаргацтай/
Ачааны татлага, бэхэлгээ материал 1. 2. 3.					
Үнэ тариф тооцох тээвэрлэлтийн зай ба тэмдэглэл					
Тарифаар төлөх тээврийн хөлс	Тээврийн хөлсний дүн	Ачаа ачсан	Буулгасан	Хадгалсан	Хураамжийн дүн
Тээвэрлэлтийн зай					
а/ ачаа илгээх үед төлөх төлбөр хураамж:					
Төлбөрийн код		Төлбөрийн хэлбэр		Тооцооны дансны дугаар	
Хүлээн авсан нийт дүн /Тоогоор болон үсгээр/		Хүлээн авсан /гарын үсэг гаргацтай/			
б/ ачаа олгох үед төлөх төлбөр хураамж					
Төлбөрийн код		Төлбөрийн хэлбэр		Тооцооны дансны дугаар	
Хүлээн авсан нийт дүн /Тоогоор болон үсгээр/		Хүлээн авсан /гарын үсэг гаргацтай/			

Усан замын тээврийн дагалдах бичгийн ар тал

Ачаа хүрэлцэн ирсэн тухай мэдэгдэл

1. Ачаагаа тээвэрлүүлэхээр зогсоолд оруулах

Огноо	Тоо ширхэг	Жин, кг	Ачаа хүлээн авсан гарын үсэг

2. Тээвэрлүүлэгч /Ачаа илгээгч/-ийн (усан замын тээврийн хэрэгслийн эзэн, жолооч, ахмадад үл хамаарах) тэмдэглэл

3. Ачааны хаягыг өөрчилсөн, замдаа буулгасан, саатсан тухай тэмдэглэл

4. Усан замын тээврийн хэрэгслийн эзэн, жолооч, ахмадын тэмдэглэл

5. Ачаа хүлээн авагчийн зогсоол дээр ачааг олгох буюу зогсоолоос ачаа гаргаж тээвэрлэх

Огноо	Тоо ширхэг	Жин, кг	Ачаа хүлээн авсан гарын үсэг

Цаг хугацааг заасан тамга тэмдгийн дардас

Тээвэрлэлтэд ачаа хүлээн авсан

Товлосон зогсоолд ачаа хүрэлцэн ирсэн

/Ачаа эвдэрч гэмтсэн, алдаж үрэгдүүлсэн, усан замын тээврийн дагалдах бичгийг үрэгдүүлсэн тохиолдолд бөглөнө/

Таних тэмдэг ба бичлэг	Ачааны тоо ширхэг	Сав баглаа боодол	Ачааны нэр төрөл	Жин, /кг/	Ачааны нэрлэсэн /зарласан/ үнэ	
					Төг	Мөнгө

Нийт дүн

Тээвэрлүүлэгч /Ачаа илгээгч/ /албан ёсны нэр/

Тээвэрлүүлэгч /Ачаа илгээгч/-ийн төлөөлөгчийн овог нэр, албан тушаал /гарцагтай/

Тамга

Огнооны дардас:




“Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын (усан замын тээврийн хэрэгслийг удирдах, жолоодох /навигаци/) дүрэм” болон “Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм”-ийн төсөлд Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага иргэд болон завь жолоодогчдоос санал авсан жагсаалт

2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр


Д/д	Эзэмшигч, аж ахуй нэгж байгууллага, иргэн	Байршил	Завь жолоодогч	Улсын дугаар	Холбоо барих	Хаяг	Санал
1.	ЗТХЯ-ны харьяа Далайн захиргаа	Хөвсгөл нуур	Б.Нэргүй	M01XӨ	88505006	Хөвсгөл аймгийн Хатгал тосгон	Тусгай зориулалтын санал Нэргүй
				M02XӨ			
2.	Б.Батцэнгэл	Хөвсгөл нуур	Б.Батцэнгэл	M03УБ	99020387	Хөвсгөл, Эрдэнэбулган, 2-р баг, Булган тал	
			Б.Батсуурь	M04УБ	99080579		
			Б.Гал-Ундрах	M99XӨ	99557270		
3.	“Хөвсгөл трэйвел” ХХК-ийн Захирал Наранчимэг 99092273	Хөвсгөл нуур	Л.Баярсайхан	M13XӨ	99380488	УБ, БЗД, 5-р хороо, “Хөвсгөл трэйвел” ХХК-ийн байр	
			Б.Мөнхсайхан	M14XӨ	96191515		
4.	Т.Гантулга	Хөвсгөл нуур	Т.Гантулга	M26XӨ	98767677	УБ, СХД, 29-р хороо, 131/6-60	
			Б.Лхагвадорж	M27XӨ	95757604		
5.	Б.Очирхүү	Хөвсгөл нуур	Б.Очирхүү	M28XӨ	98613026, 98613027	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 1-11 тоот	
6.	Б.Отгонсэлэнгэ	Хөвсгөл нуур	Б.Отгонсэлэнгэ	M30XӨ	99031050,	УБ, СБД, 14/4 байр, 4 тоот	
				M31XӨ	96630804		
7.	Б.Гантулга	Хөвсгөл нуур	Б.Гантулга	M32XӨ M33XӨ	98389659, 98390098	Хөвсгөл аймаг, Мөрөн хот, 9-р баг, 49-6 тоот	
8.	Б.Ганзориг,	Хөвсгөл нуур	Т.Наранбаатар	M33XӨ	98070727		

13Х ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн даргын 17-н дугаар тушаал


					98666982		- 3 SanDer - CaNalim
9.	Жанхай тур	Хөвсгөл нуур	Л.Аззаяа	M35XӨ	94642727	УБ,ХУД, 11-р хороо, 4-4тоот	
10.	Ө.Нямбаяр	Хөвсгөл нуур	Б.Баярхүү Ж.Чулуунбаатар	M36XӨ M37XӨ	90191661 99383091		Э.Н. Дорж
11.	Т.Мөнхтэнгэр,	Хөвсгөл нуур		M38XӨ		Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон, 3-р хороо	
12.	"Монтрэвел"ХХК -ийн захирал н.Эрдэнэ-Уул	Хөвсгөл нуур		M39XӨ	99993916	УБ, Сөүлийн гудамж	
13.	П.Батхуяг	Хөвсгөл нуур		M42XӨ	93048282	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон	
14.	К.Батхуяг	Хөвсгөл нуур	К.Батхуяг	M43XӨ	98175037, 98148031, 98667018	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон, Жанхай	
15.	Н.Нямхүү	Хөвсгөл нуур		M44XӨ	88398028	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Жанхай, Хирвэстэг	
16.	"Хөвсгөл усан зам" ХХК	Хөвсгөл нуур		M45XӨ	75779999	Хөвсгөл аймаг, Хатгал тосгон, Усан зам боомт	
17.	"Тосгол" ХХК	Хөвсгөл нуур		M46XӨ	62263026	УБ, БГД, 13-р хороо, 3-р хороолол, 2Г-21 тоот	
18.	Г.Мэндбаяр	Хөвсгөл нуур		M47XӨ	88111203, 88114030	УБ, ЧД, 5-р хороо, 2а байр, 52 тоот	
19.	"Ашихай" ХХК	Хөвсгөл нуур		M49XӨ			
			Б.Хүрэлцоож	M50XӨ	96778500	УБ, ЧД, 1-р хороо sales@huree.mn	
				M51XӨ			



20.	"Мөнх-Эрин Трэвел"ХХК	Хөвсгөл нуур	Б.Төгсөө	M52XӨ	99790823, 98079779 98904790	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон, 2-р гудамж 22 тоот	
			Б.Мөнх-Эрдэнэ	M53XӨ	99235585		
			О.Өнөрболд	M54XӨ	98222225		
21.	Эртний далай ж.б	Хөвсгөл нуур		M55XӨ	99122194	УБ хот, www.otog.mn	
22.	А.Давааням	Хөвсгөл нуур	Д.Баттүшиг	M57XӨ	98777180	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон,	<i>Тусгайлан авч санаа хатуу Баттүшиг. Санаагч А. Давааням.</i>
			А.Давааням	M58XӨ			
				M59XӨ			
				M60XӨ			
				M62XӨ			
23.	"Монгол нуур" ХХК Хөвсгөл далай ж.б	Хөвсгөл нуур		M63XӨ	98114408	УБ хот	
24.	Д.Пүрэвцогт	Хөвсгөл нуур		M64XӨ	91798188	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон, 1-р хороо, 19 тоот	
25.	Д.Саранцэцэг	Хөвсгөл нуур		M68XӨ	98616603, 89720188	Хөвсгөл аймаг, мөрөн хот, 13-р баг, 2-20тоот	<i>Тусгайлан авч санаа хатуу Санаагч Д.Саранцэцэг</i>
				M98XӨ			
26.	З.Даваа	Хөвсгөл нуур		M69XӨ		Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон	
27.	Б.Нямдалай	Хөвсгөл нуур		M70XӨ	98099119, 88120770	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 1- 20-13тоот	
28.			Б.Ууганбаяр	M93XӨ	99718998		
29.	З.Анхбаяр	Хөвсгөл нуур		M71XӨ	89744080	Хөвсгөл аймаг, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 1- 9-16тоот	
30.	Ж.Эрдэнэбилэг	Хөвсгөл нуур		M72XӨ	99662030, 91662030	УБ, СХД, 9-р хороо, Малчин 2 гудамж, 13 тоот	



31.	Л.Норовсамбуу	Хөвсгөл нуур	Л.Норовсамбуу	M82XӨ	99978369	Улаанбаатар, СХД, 24-р хороо, зээл 9-р гудамж 34 тоот	
32.	Б.Баттулга	Хөвсгөл нуур		M83XӨ	98389659	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 14-р баг, 28-6 тоот	Дэлгэрмж Тогтоо
33.	Б.Чинбат	Хөвсгөл нуур	Б.Чинбат	M84XӨ	98388589	Хөвсгөл, Хатгал тосгон, Жанхай	
34.			Б.Ганжаргал	M85XӨ	98987422		
35.			Б.Лхагвасүрэн	M106XӨ	98380458		
36.	"Агуужим Аз" ХХК	Хөвсгөл нуур	Д.Энх-Амгалан	M87XӨ	99192022		
37.	"Жавхлант нарангэрэл"ХХК	Хөвсгөл нуур		M88XӨ			
38.	Б.Билгүүн	Хөвсгөл нуур	Б.Билгүүн	M89XӨ	98087777	Хөвсгөл, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 3-9-9 тоот	
39.	З.Ганхуяг	Хөвсгөл нуур	З.Ганхуяг	M90XӨ	98249732	Хөвсгөл, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 1-р хороо, 5 тоот	
40.	Б.Борбаатар	Хөвсгөл нуур	Б.Борбаатар	M91XӨ	99769695	Хөвсгөл, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 1-1 тоот	98963434
			Э.Жаргалтуяа	M92XӨ	88923161		
41.	Ц.Мягмардорж	Хөвсгөл нуур		M100XӨ	99236650	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 9-р баг 17-р гудамж 20 тоот	
42.	Б.Билгүүн	Хөвсгөл нуур	Б.Билгүүн	M111XӨ	98087777	Хөвсгөл, Алаг эрдэнэ, Хатгал тосгон 3-9-9 тоот	
43.	Э.Алтансүх	Хөвсгөл нуур	Э.Алтансүх С.Наранчулуун	M112XӨ	99027717 99027712	УБ, БЗД, Энхтайваны өргөн чөлөө, 101-102 тоот	
44.	"Бамбай секьюрити"ХХК	Хөвсгөл нуур	М.Мөнххуяг	M113XӨ	94110097	УБ, БЗД, 18-р хороо, 13-р	



45.				M114XӨ		хороолол, 39г байр	
Нийт							
Завь жолоодогчид							
46.	П.Намуунбаяр				91798188		Хамгийн Буйна М.Нэгд
47.	Г.Батмөнх				96618191		
48.	С.Батсуурь				99369365		
49.	А.Алтанхүү				99363050		
50.	Б.Занабазар				99603218		
51.	Б.Бат-Эрдэнэ				99759746	98381911	Батмөнх (санамс)
52.	Д.Улаанхүү				88754296		
53.	М.Пүрэвдалай				89375060		
54.	Т.Батням				86559988		
55.	Б.Гансүх				86653223		
56.	Д.Энхтайван				94996363		
57.	М.Ганбаатар				93029147		
58.	Б.Анхбаяр				98383070		
59.	З.Ганболд				89207431		
60.	Г.Лувсандаш				99034490		
61.	Д.Энхпүрэв				98383522		
62.	Д.Саруулболд				98477677		Санамсгүй Саруулболд
63.	Д.Эрдэнэболд				98777009		
64.	Д.Саруулбуян						


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА ДАЛАЙН ЗАХИРГАА

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо,
Самбуугийн гудамж, Засгийн газрын XI байр, 601, 606, 612 тоот

Утас: (976-11) 261488, 261489, 261490
88071418,

Факс: (976-11) 310642

И-мэйл: info@monmarad.gov.mn



ТАЙЛБАР

Дүрмийн төсөлд санал авахаар
хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай

2017 оны 09 дүгээр
сарын 15-ны өдөр

Хөвсгөл аймгийн
Хатгал тосгон

Далайн захиргааны даргын 2017 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 11 тоот түшаалаар байгуулсан ажлын хэсэг "Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм" болон "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"-ийн төслүүдтэй танилцаж, холбогдох саналыг 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 01/229 тоот албан бичгээр хүргүүлсэн билээ.

Түүнчлэн "Захиргааны ерөнхий хууль"-д нийцүүлэх зорилгоор дүрмийн төслүүдийг усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн дунд хэлэлцүүлж, санал авах зорилгоор 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд ЗТХЯ-ны Зам, тээврийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн, улсын байцаагч Б.Нэргүй, Далайн захиргааны мэргэжилтэн, улсын байцаагч Б.Бямбажаргал нар удирдан зохион байгууллаа.


Энэхүү хэлэлцүүлгийг нээлттэй хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд нийт 30 гаруй иргэд, аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон бөгөөд хэлэлцүүлгийн явцад оролцогчдоос дүрмүүдийн төсөлд санал өгөх тодорхой хугацаа өгөх хүсэлт тавьсны дагуу зохион байгуулагчдын зүгээс санал авах хугацааг 10 хоногоор түр хойшлуулсан.

Түүнчлэн тодорхой шалтгааны улмаас хэлэлцүүлэгт хүрэлцэн ирж, оролцоогүй иргэдэд дүрмийн төслүүдийг хувиалан тараасан байсан бөгөөд мөн хугацаанд багтан саналаа ирүүлэхээр болсон юм.

Дээрх хугацаанд нийт 14 аж ахуйн нэгжийн төлөөлөл, иргэдээс тодорхой саналгүй болон төслийг бүхэлд нь дэмжиж байгаа талаар хариуг хэлэлцүүлэг зохион байгуулагчдад ирүүлсэн ба бусад аж ахуйн нэгж, иргэдээс тодорхой саналгүй гэдгээ утсаар мэдэгдсэн болно.

"Усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын дүрэм" болон "Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэх дүрэм"-ийн төслүүдтэй танилцаж, саналаа өгсөн иргэдийн нэрсийн жагсаалтыг энэхүү тайлбарт хавсаргав.

Хэлэлцүүлэг зохион байгуулсан:

Б.Нэргүй
/ЗТХЯ-ны Зам, тээврийн хяналтын
хэлтсийн мэргэжилтэн, улсын
байцаагч/ 

Б.Бямбажаргал 
/Далайн захиргааны мэргэжилтэн,
улсын байцаагч/

